



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.03.16, БААСАН ~ №055 (854)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

"Тэнэмэл" төлөөлөгчидтэй нийслэлийн хурлыг тараая

НИТХ-ын нэг төлөөлөгч улиралд 10 сая төгрөгийн урамшуулал авдаг. > 2

Газар гэслээ, Ерөнхийлөгч өө, ажлаа эхлэх үү?

Мега төслүүдээ хөдөлгөх ёстойг тэр эртнээс анхааруулж, сануулж байсан. > 5



■ Цахим бизнест оруулсан хөрөнгө ашигтай байна
■ Азийн хувийн хэлцлүүд дээд хэмжээнд хүрлээ

ZGM DAILY

Development of robotics demand multiple professions from employee

Mechatronic engineers to be prepared in Mongolia. > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

ОХУ-ын Төрийн тэргүүн В.Путин Ерөнхийлөгч Х.Баттулгад мэндчилгээ дэвшүүлэв.
У.Хүрэлсүх: Эрчүүд рүү чиглэсэн бодлого дутмаг байгааг анхааралдаа авна.
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн чуулганд УИХ-ын эмэгтэй гишүүдийн төлөөлөл оролцож байна.
АН: Зөрчлийн хууль хэрэгжсэнээр иргэдэд эдийн засгийн дарамт үзүүлж байна.

ЭДИЙН ЗАСАГ

Литийн эрэлт өссөөр 2025 онд 600 мянган тонн давна.
"ЛэндМН ББСБ" компанийн хувьцааны ханш хоёр өдөр дараалан өсөв.
Монголбанк энэ он гарсаар хоёр тонн алт худалдан авчээ.
"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" нийт 26.7 тэрбум төгрөгийн төсөл санхүүжүүлэв.
"ТОП 20" индекс 20573.52 нэгж болж, 0.99 хувиар буурлаа.



НИЙГЭМ

МҮЭХ Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороог хуралдуулахыг шаардлаа.
2017 онд 3430 эмэгтэй, 430 хүүхэд гэмт хэргийн хохирогч болжээ.
ШЕЗ-өөс шүүгчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг ил болголоо.
ЭМЯ хөрсний бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах зөвлөмж гаргав.

ДЭЛХИЙ

Худалдааны сөргөлдөөн нэмэгдсэний улмаас Засгийн газруудын бондын ханш өслөө.
Дэлхийн нийт өрийн хэмжээ 233 их наяд ам.доллар хүрснийг шинжээчид анхааруулав.
ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Герман, Финландын ажиглагчид Крымд ирнэ.
Хятадын Жансу мужийн удирдлага агаарын бохирдолтой дайн зарлахаа мэдэгдэв.
Орост ирдэг АНУ-ын жуулчдын тоо 2017 онд 25 хувиар өсчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2018.03.16

☀️ | ☁️
4° | -11°


ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭЭЖИЙН МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРГУУС УНШИНА УУ

8 658 000 4029 112 0 08 54

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

РОБОТУУДАД АЖЛАА АЛДАХГҮЙН ТУЛД ГУРВАН МЭРГЭЖИЛТЭЙ БАЙХ ХЭРЭГТЭЙ



Хиймэл оюун ухаанд тулгуурласан шинэ эринд роботуудыг удирдах хамгийн эрэлттэй мэргэжилтнийг манай улс бэлтгэж эхэллээ. ▶12

ЗГМӨ

ЦАГ ҮЕ

Эмнэлэгт үзүүлэхийн тулд үүрээр босож цаг авч байна

Эрүүл мэндийн салбарын үйлчилгээ бүтэн нэг зуунаар хоцрогдсон

Б.Бямбасүрэн
@byambabaab_zgm

Техник технологийн эрэн зуунд амьдарч байгаа атал манай улсын эрүүл мэндийн салбар, ялангуяа улсын эмнэлгийн тусламж үйлчилгээ бүтэн нэг зуунаар хоцрогдсон хэвээр олон жилийг үлдээ. Өнөөдөр улсын

эмнэлэгт үзүүлэх цахим цаг авахын тулд мянгуужингийн адал явдал лугаа ээдрээтэй зам туулах шаардлагатай болов. Өвчин хүн бүрт хэлж биш хийсч ирдэг гэдэг. Тиймээс аливаа өвчнийг эрт үед нь илрүүлж, оношлох нь хамгаас чухал. Үүний тулд жил бүр шинжилгээ өгч байхыг эмч, мэргэжилтнүүд байнга зөвлөдөг. Гэсэн ч өнөөдөр улсын эмнэлэгт урьдчилан сэргийлэх шинжилгээ өгөх нь бүү хэл, яаралтай эмчид үзүүлэх цаг авахад ч тун бэрх боллоо. Нэг үеэ бодвол эрт босож, цаг авч чадвал басхүү учиртай болсон гэж ахмадууд ярьж байна. Нээрэн л тийм.

▶4



142 тэрбум ам.долларын хэлцэл зогслоо

Эрик Платт, Жэймс Фонтанелла-Хан

Сингапурт бүртгэлтэй, чип үйлдвэрлэгч өрсөлдөгчөө өөртөө нэгтгэх наймаанд Ерөнхийлөгч Дональд Трамп хориг тавьсан. Үүнээс хоёр хоногийн дараа Broadcom компани Qualcomm-ыг 142 тэрбум ам.доллараар худалдаж авах саналаа эргүүлэн татлаа. Ерөнхийлөгч Дональд Трамп уг наймааг үндэсний аюулгүй байдалтай холбон үзэж хориглосон юм. Түүхэндээ технологийн хамгийн том наймаа

болж үлдэх байсан, мөн сүүлийн үеийн дайсагнасан ширүүн нэгтгэх тэмцлийн нэг ийнхүү өндөрлөв.

Уг наймаа 5G технологи хөгжүүлэх өрсөлдөөнд Хятад улс АНУ-ыг гүйцэж түүрүүлэх нөхцөл болно хэмээн АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын удирдлага анхааруулсан юм. Үүний дараа ноён Трамп транзакцийг зогсоох шийдвэр гаргасан нь Broadcom бууж өгөх нөхцөл болжээ.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК

ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
(2015-2016 оны хичээлийн жил)

НИЙТ 44.9 мянган төгсөгчөөс 4909-ийг түүвэрлэж судлахад:

- 60.9% ажилтай
- 68.4% их, дээд сургууль төгсөгч
- 31.6% МСҮТ-ийг төгсөгч хөдөлмөр эрхэлдэг

Харин 39.1 хувь нь ажилгүй байна

ТӨГСӨГЧИД АЖИЛГҮЙ БАЙГАА ШАЛТГААН:

- Ажил олдохгүй: 54.1%
- Мэргэжилд тохирох ажил олдохгүй: 25.5%
- Цалин бага: 5.3%
- Ажил олгогчийн шаардлагад нийцэхгүй: 4.9%

Улаанбаатар: 32% | Орон нутаг: 68.6%

Ажилгүй төгсөгчдийн

БСШУСЯӨ

ЗГМ: ЗОЧИН

Хурандаа аавын хурандаа охин

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Зэвсэгт хүчний түүхэнд эмэгтэй хурандаа нэгээр нэмэгдлээ. Шинэхэн хурандаа Х.Эрдэнэчимэг Энхийг сахуулах ажиллагааны хангалт, арын албанд зүтгэдэг. Цэргийн гэр бүлээс гаралтай, салбартаа 23 жил ажилласан тэрбээр ЗХЖШ-ын Энхийг дэмжих цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн Энхийг дэмжих ажиллагааны ар тал хангалт, дэмжлэгийн тасгийн даргаар ажилладаг. Монголын тав дахь эмэгтэй хурандаа болсон түүнийг Монгол цэргийн баярыг тохиолдуулан зочноор уриалаа.

-Хурандаа цол хүртсэнд тань баяр хүргэе. Уншигчдад өөрийгөө танилцуулна уу?

-Баярлалаа. Би 1995 онд Батлан хамгаалахын их сургуулийг төгссөн анхны эмэгтэй офицеруудын нэг. Аав, ээж маань Сүхбаатар аймгийн хүмүүс. Хоёулаа цэргийн хүн болохоор бага нас маань цэргийн хотхонд өнгөрсөн. Ээж цэргийн эмчээр 20 жил, аав артиллерийн салбарт 33 жил ажилласан. Ер нь би төрсөн цагаасаа эхлээд цэргийн хүмүүсийн дунд амьдарч байна. Бага байхад аав, ээж маань Төв аймгийн Сэргэлэнгийн дивизэд ажиллаж байгаад Өвөрхангай аймгийн Их-Уул хорооны 256 дугаар анги руу томилогдсон.

▶3

АЛТ 1325.24 0.39%	ЗЭС 6910 0.17%	10-ЧИНГИС БОНД 98.750 0.06%	ГЭРЭГЭ БОНД 100.08 0.03%	ХУРАЛДАЙ БОНД 114.02 0.00%	АМ.ДОЛЛАР 2393.92	ЮАНЬ 377.43	РУБЛЬ 42.31
--------------------------------	-----------------------------	--	---------------------------------------	---	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

УЛААНБААТАР

2018 оны эхний улирлын урамшууллаа НИТХ-ын 45 гишүүн авсан

Б.Энхжаргал @enkhjirgZGM

“ТЭНЭМЭЛ” ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫГ ТАРААЯ

НИТХ-ын төлөөлөгчид гэдэг ёс зүй, үүрэг хариуцлагаа умаргсан сул “тэнэмэл” хүмүүс байх болов. Хүний урманд хуралдаа хагас дутуу ч суухгүй байж НИТХ-ын гишүүний эрхээ эдэлж, улирал тутамд урамшууллаа авч яваа тэдэнтэй хэн хариуцлага тооцох вэ?

Тэргүүлэгчдийн хурлаа хуралдуулж бараагүй НИТХ-ын дарга С.Амарсайханы өгсөн ярилцлага өчигдрийн зарим хэвлэлд гарчээ.

“...НИТХ-ын нэг төлөөлөгч улиралд 10 сая төгрөгийн урамшуулал авдаг. Татвар хураамжаа хасаад тооцохоор төлөөлөгч бүр улиралд 7.9 сая төгрөгийн урамшуулал авч байгаа...” гэсэн байв. Хайран мөнгө. Татвар төлөгчид улиралд 450 сая, жилдээ 1.8 тэрбум төгрөгөөр НИТХ-ын төлөөлөгчдийг урамшуулж байна. Зориулалтыг нь заагаагүй, зарцуулалтыг нь хянадаггүй. Шулуухан хэлэхэд сул мөнгө.

Нийслэлийн иргэдийг төлөөлж буй 45 эрхэм ажилдаа ирдэггүй, хотын “парламент” хурлаа хийж чаддаггүй байдалд ордог гэдгийг бид ганц энэ удаа харж байгаа юм биш.



Татвар төлөгчид улиралд 450 сая, жилдээ 1.8 тэрбум төгрөгөөр НИТХ-ын төлөөлөгчдийг урамшуулж байна. Зориулалтыг нь заагаагүй, зарцуулалтыг нь хянадаггүй.

С.Батсайхан / ЗГМ

руулахтай холбоотой асуудлыг ярихаар хэсэг бүлгийн эрх ашиг хөндөгдөж байна. Эргээд эсэргүүцэлтэй тулгарч байгаа нь илт болсон.

● Нийслэлийн иргэдийг төлөөлж буй 45 эрхэм ажилдаа ирдэггүй, хотын “парламент” хурлаа хийж чаддаггүй байдлыг олон удаа харж байна.

● НИТХ-ын төлөөлөгчдөд хариуцлага тооцох ганц зам нь эргүүлэн татах.

● Тусдаа хангамжтай, төсөвтэй төлөөлөгчдийг заавал урамшуулах шаардлагагүй.

Хуулиа биелүүлж, нийслэлийн иргэдийн эрх ашгийн төлөө ажиллаж чадахгүй бол тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хөндөх болно...” гэв. НИТХ-ын төлөөлөгчид бол сонгогдсон албан тушаалтнууд. Тэдэнд хариуцлага тооцох ганц зам нь эргүүлэн татах. Эсвэл хурлыг бүрхэлд нь тараах сонголт бий. Харин Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийг эргүүлэн татах, огцруулахтай холбоотой заалт бий. Хуульд төлөөлөгч нас барсан, хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан, өвчний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх

боломжгүй болсон, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон, тухайн орон нутгаас шилжсэн тохиолдолд хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгодог гэж. Харин энд хуралдаа суудаггүй, иргэдийн ахуй амьдрал, орон нутгийн хөгжил дэвшил, бүтээн байгуулалттай холбоотой асуудал хэлэлцэх, шийдвэр гаргахад хойрго хандсан тохиолдолд тооцох хариуцлагын талаар нэг үсэг ч алга. Мэдээлэлд ойр, шийдвэр гаргахад оролцдог, албан тушаалд хүн томилох эрхтэй бас халаа сэлгээ хийж чаддаг гээд НИТХ-ын төлөөлөгч “унац” ихтэй албан тушаалд ордог нь нууц биш. Мөн төлөөлөгчид бараг бүгдээрээ л шахуу аль нэг төрийн өмчит байгууллагын

даргын албыг хашдаг. Тусдаа хангамжтай, төсөвтэй төлөөлөгчдийг заавал урамшуулах шаардлага байна уу.

НИТХ-ын нэг төлөөлөгч улиралд 10 сая төгрөгийн урамшуулал авдаг

Хуульд “Төлөөлөгчдийн хурлын ажилд оролцсон байдлыг харгалзан тэдгээрт тэргүүлэгчид урамшуулал олгож болох бөгөөд хэмжээ, журмыг нь

аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал баталж шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгана” гэж заасан байдаг. Урамшуулал олгож болно гэдэг нь өг гэсэн үг биш. Хэрэв анзаарсан бол “хурлын ажилд оролцсон байдлыг нь харгалзан” гэж заасан. Гэтэл 2018 оны эхний улирлын урамшууллаа НИТХ-ын 45 гишүүн авсан бөгөөд хуралд хэрхэн оролцсон, хэдэн удаа ажилдаа ирснээс үл хамааран тус бүр 10 сая төгрөг авсан гэдгийг эх сурвалж хэлж байна. Эрх мэдэл, ямба хэргэм өгч байгаа шингээ үүрэг хариуцлагыг нэхэх нь зүй ёсных. Харин нэгэнт ийм зарчмаар ажиллаж чадахгүй байгаа НИТХ-ыг тарааж, хариуцлага тооцье. [ЗГМ]

[ЗГМ СОНИН]
“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.
ТУЗ-ийн дарга Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч Баатарын ДУЛАХОРЛОО
Зөвлөх Шатарбалын ДАВААДОРЖ
Орлогч эрхлэгч Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584
РЕДАКЦ
Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба Эдитор Б.Даваатогтох Утас: 99901637
Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба Эдитор Б.Баяртөгтох Утас: 99901532
Цахим контент, бүтээгч үйлдвэрлэлийн алба Эдитор Г.Балсайхан Утас: 99903574
ЗАР СУРТАЛЧИЛГАА
Утас: 99903581 99903578 99909472 99907843
ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Блю Скай тауэр” 407 тоот Улсын бүртгэлийн дугаар, 1024
Утас: 70103131, Факс: 7010606
ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn
Дугаарын удирдагч Б.Даваатогтох

ЗАСГИЙН ГАЗАР Жендэрийн тэгш эрхэд эрчүүдийг анхаарах цаг болжээ



Б.Сэлэнгэ ЗГМ
Жендэрийн тэгш эрхийн тухай асуудлыг ихэвчлэн эмэгтэйчүүдийн эрх зөрчигдсөн талаарх тохиолдлоор ойлгодог. Гэвч энэ нь илүү өргөн хүрээний, нийт иргэдийн тэгш эрхийн тухай гэдгийг олон нийт мэддэг болсон гэж Ерөнхий сайдын ахлан явуулсан Жендэрийн үндэсний хорооны ээлжит хуралдаанд оролцогчид онцолж байна.
Тус хорооны өнгөрсөн оны тайланд тусгагдсан баримтууд эрэгтэйчүүдэд анхаарлаа хандуулах шаардлага үүссэнийг илтгэж байна. Эргэтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү сөн жил, тухайн жилд нас барагсдын 60 гаруй хувь нь эрэгтэй, эрчүүд эмэгтэйчүүдээс 5.5 дахин их амиа хорлосон, зам тээврийн осолд өртөх тохиолдол 3.4 дахин их байдаг зэрэг мэдээлэл тус тайланд тусгагджээ. Жендэрийн үндэсний хорооны гишүүн Я.Пүрэвдорж “Иргэдээ эх орондоо ажиллах боломжоор хангаач ээ. Идэр насны ихэнх эрчүүд ажлын байр хайж гадагшаа гарч байна. Үүнийг дагасан гэр бүл салалт зэрэг сөрөг үзэгдлүүд газар авлаа. Ийм томоохон “нүүдэл”-ийн 97 хувийг эрчүүд эзэлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон” гэв.
Мөн гурван аймгийн 20 гаруй суманд биечлэн асуулт, ярилцлага хэлбэрээр явуулсан судалгаагаар гэр бүлд жендэрийн тэгш эрх алдагдаж байгаа хэд хэдэн ноцтой шалтгаан байсан аж. Нэн тэргүүнд ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг зургаан наснаас оруулах явдлыг нэрлэж байна. Зургаан настай хүүхдээ дагаж эцэг, эхийн хэн нэг нь сумын төвд амьдарснаар гэр бүл нь түр болон бүр хугацаагаар салдаг. Үүнийг дагаж эрчүүдийн архидалт өсөж, эрүүл хооллолтын дэглэм алдагдаж, эмэгтэйчүүд нь ажлын байргүй учир ядууралд өртдөг байна. [ЗГМ]

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ Жолооч нар давхар торгуулах ёсгүй

“Зөрчлийн хуулийн зөрчлийг арилгая” сэдэвт хэлэлцүүлэг өчигдөр Төрийн ордонд болов. Тус хууль хэрэгжиж эхэлснээс хойш найман сар гаруйн хугацаа өнгөрч буй. Гэвч дээрх хуулийн хэрэгжилттэй холбогдуулан иргэд, төрийн байгууллагуудаас гомдол санал олонтаа ирэх болсон. Тухайлбал, замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч осол гаргасан тохиолдолд даатгалын байгууллага болон Замын цагдаагийн газарт дуудлага өгдөг. Дуудлагын дагуу ирсэн замын цагдаа тухайн жолоочид гаргасан зөрчилд нь тохирсон торгууль тавьдаг.
Харин жолооч ослоос бий болсон хохирлоо барагдуулахын тулд даатгуулсан даатгалын компанидаа хандахад цагдаагийн нотолгоо шаарддаг аж. Шаардлагынх нь дагуу даатгуулагч цагдаа дууддаг. Гэвч цагдаа жолоочид торгууль тавьснаар давхар торгуулдаг болжээ.
Харин цагдаагийн байгууллагын төлөөлөгчийн тайлбараар бол хүний амь нас хохирсон эсвэл биед нь гэмтэл учруулаагүй, жижиг хэмжээний зөрчилд даатгалын байгууллагаас нотолгоо шаардах ёсгүй. Хохирлыг нь барагдуулах бүрэн боломжтой. Хуульд энэ чиглэлийн зохицуулалт бүрэн туссан. Харамсалтай нь, энэ зохицуулалтыг даатгалын байгууллагууд хэрэгжүүлдэггүйгээ иргэд давхар торгуулж байгаа тухай гомдлыг тавих болсон аж. Цаашид иргэд ийм асуудалд орохгүйн тулд даатгалын компаниуд гэрээ байгуулахдаа нарийн заалт тусгаж өгөх ёстой гэсэн юм. [ЗГМ]

Bloomberg TV MONGOLIA
STUDIO | 1.0
20:00
11:30 МЯГМАР ГАРАГ /ДАВТАЛТ/
Амралтын өдрүүдээр /давталт/
Studio 1.0 нэвтрүүлгийн энэ удаагийн зочноор Microsoft-ийн гүйцэтгэх захирал Сатья Наделла оролцож байна. Microsoft-ийг хамтран үүсгэн байгуулагч Билл Гейтс ТУЗ-ийн даргын ажлаа хүлээлгэн өгч компанийн тусгай зөвлөхөөр ажиллаж болсон. Гэхдээ Наделла удирдлагыг гартаа авсанаас хойш хувьцааны ханш 100 гаруй хувирч өсөж, компани клауд тэргүүтэй шинэ салбаруудад ч орж эхэлсэн.
Hit Refresh гэх анхны номондоо Сатья Наделла өөрийн хувийн амьдрал, Microsoft дахь карьер болон хиймэл оюун ухаан ирээдүйг хэрхэн тодорхойлох талаар хуваалцсан юм.

ЗГМ: Зочин

Хурандаа аавын хурандаа охин

Зэвсэгт хүчний арын албыг бүсгүйчүүд авч явдаг

Аавын ажил өөрчлөгдвөл миний сургууль бас өөрчлөгддөг байлаа.

Би Өвөрхангай аймгийн нэгдүгээр дунд сургуулийг төгсөөд Батлан хамгаалахын их сургуулийн эдийн засгийн ангид орсон юм. Тухайн үед анх удаа арын албанд эмэгтэй сонсогч авч байсан учраас охид энэ мэргэжлийг их сонирхож байлаа. 600 хүүхдээс шигшигдээд нэгдүгээр байрт орж байсан шүү.

-Таныг буудлагын торлийн олон медаль, шагналтай гэж сонслоо. Ямар амжилт гаргаж байв?

-Батлан хамгаалахын сургуульд цэргийн ерөнхий эрдмийн хичээл үздэг. Эрчүүдтэй адил буудах, давших тактик заалгасан. Сонсогч болсноосоо хойш буудлагыг илүү сонирхдог болж, олон тэмцээнд оролцсон. Би 9мм РМ гар буугаар мэргэшсэн л дээ. Зэвсэгт хүчний армийн аварга шалгаруулах тэмцээний алт, мөнгө, хүрэл медальтай. 2003 онд түргэн буудлагын алтан медаль авч байсан. Саяхан жанжин штабын газар, хэлтсүүдийн дунд болсон "Цол бүхэн сайхан" тэмцээнд манай дэд хурандаа нарын баг хоёрдугаар байрт орсон.

-Яагаад цэргийн хүн болохоор шийдсэн юм бэ? Эмэгтэй хүнд хэцүү мэргэжил шиг санагддаг.

-Багадаа бусад охидын адил дуучин, бүжигчин болно гэж мөрөөддөг л байсан. Харин дунд сургуульдаа орос хэлний гүнзгий сургалттай ангийг төгссөн учраас хэлний чиглэлээр сурна гэж боддог байлаа. Гэхдээ л хувь заяаны эрхээр цэргийн хүн болсон доо.

-Таны аав хурандаа хүн. Зэвсэгт хүчний алба хаагч болоход аав тань нөлөөлсөн үү. Ер нь хурандаа аав охиндоо юу гэж захидаг вэ?

-Миний аав артиллерийн хурандаа Г.Халтар гэж хүн бий. Одоо 70 нас шүргэж яваа гүндүүгүй сайхан хүн. Аав маань ажил дээрээ их ширүүн харцтай, чанга хатуу дарга байдаг бол гэртээ огт өөр хүн болчихдог. Тэг, ингэж гэж шаарддаггүй, ямагт үлгэр жишээ үзүүлдэг ер бусын хүн. Ер нь цэргийн дарга гэдэг онцгой алба. Би зөвлөн зантай хүн гээд өөрийнхөөрөө байж болдоггүй. Алба л бол алба гэдэг зарчмаар цэргийн хатуу дүрэм, журмыг мөрдөх л ёстой. Гэхдээ мэддэг, хүнээ бодолгүй яах вэ.

-Таны гэр бүлийн хүн ямар мэргэжилтэй вэ. Ажлын шаардлагаар гэнэт дуудагдах үед эргийн асуудлаа хэрхэн зохицуулах уу?

-Хань маань бас л цэргийн хүн, 1999 онд их сургуулиа цуг төгссөн. Одоо Батлан хамгаалахын дээд сургуулийн "Түшиц" найрал хөгжмийн

удирдаачаар ажилладаг. Харин охин маань наймдугаар ангид, хүү тавдугаар ангид сурдаг. Нөхөр маань миний ажлыг ойлгодог учраас харьцангуй амар байдаг. Үүнийг хэлэхэд эргийн ачааны ихэнхийг нөхөр маань л үүрдэг дээ.

-Нууц биш бол хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй монгол цэргүүдийн орчин, нөхцөл хэр байдаг вэ. Танай Энхийг дэмжих ажиллагааны ар тал хангалт, дэмжлэгийн тасаг ямар үүрэгтэй ажилладаг юм бэ?

-Айл гэрийг эмэгтэй хүн авч явдаг шиг цэргийн салбарын арын албыг бүсгүйчүүд авч явдаг. Бид цэргүүдийг үүрэг гүйцэтгэх нөхцөл, бололцоог тасралтгүй хангах ёстой. Үүний тулд маш сайн төлөвлөж, урдаас харж, бэлтгэсэн байх шаардлагатай болдог. Одоогоор энхийг сахиулах үйл ажиллагаанд манай улсын 14 мянга гаруй цэрэг оролцоод байна. Жилд 1100 гаруй хүн энэ ажиллагаанд хамрагддаг. Бид цэргүүдийн бүх хувцас, хэрэгслийг бэлддэг. Дараа нь НҮБ-тай хийсэн хамтран ойлголцох санамж бичгийн хүрээнд нөхөн төлбөр авдаг юм.

Өмнөд Судан бол дайн дажин татраагүй, цагийн байдал тогтворжоогүй газар учраас цэргүүд аюулгүй байдал, эрүүл мэнддээ хамгийн түрүүнд анхаарах ёстой. Монголоос явахдаа сар гаруй бэлтгэл хийдэг учраас хүндрэл харьцангуй бага гардаг.

-Энхийг сахиулах үйл ажил-



Хурандаа Х.Эрдэнэчимэг Зэвсэгт хүчний армийн аварга шалгаруулах тэмцээний буудлагын алт, мөнгө, хүрэл медальтай.

С.Батсайхан / ЗГМ ©

лагаанд оролцож байгаа монгол цэргүүд олон улсын хэмжээнд сайнаар үнэлэгддэг. Монгол цэргүүдийн бусдаас ялгардаг чадварыг юунд байна гэж боддог вэ?

-Би 2011-2012 онд баруун Сахарт НҮБ-ын цэргийн ажиглагчаар ажилласан. Дараа нь ажлын шугамаар Афганистанд очсон. Манайх Энхийг дэмжих ажиллагааныхаа гарааг анхнаасаа сайн тавьж өгсөн. Дараагийн үе нь энэ нэр хүндийг унагахгүйн тулд бүгдээрээ хичээлдэг. Монголчуудын сахилга, зохион байгуулалт мэргэжлийн түвшинд очсон. Бас их бүтээлч. Очсон газартаа амьдрах орон сууц, орчноо байнга засаж, сайжруулж байдаг учраас монголчуудыг

"ажилчин зөгий" гэдэг юм билээ.

-Энэ салбарт 23 жил ажиллажээ. Энэ хугацаанд манай улсын зэвсэгт хүчний салбарт ямар өөрчлөлт мэдрэгдэж байна вэ?

-1990-ээд оны эхэн үед нийгмийн байдал зэвсэгт хүчинд ч бас нөлөөлж байсан. Хүмүүсийн албандаа хандах хандлага, итгэл буурсан байлаа. Цэрэгт явах хүн олддоггүй, нуугдаж, зугтдаг байсан үе. Тэр үетэй харьцуулбал зэвсэгт хүчин хөгжиж, үүнийг дагаад хүмүүсийн хандлага өөрчлөгдсөн. Зэвсэгт хүчний салбар өөрөө мэргэжлийн байх зорилт тавьсан, үүний төлөө хүн бүр зүтгэж байгаа. Залуус ч ажилдаа мэргэших, хамгийн сайн нь болох зорилготой болжээ.

Манай салбар бусад өндөр хөгжилтэй орнуудын жишигт ойртохын төлөө зүтгэдэг. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо бидэнд сайнаар нөлөөлж байгаа. Хэлтэй, өөрөө зүтгэлтэй бол НҮБ, цаашлаад олон улсад ажиллах боломж ч нээгдсэн.

-Хурандаа цолыг олон жил ажилласан ч гэсэн хүн бүрт өгдөггүй. Цөөхөн эмэгтэй хурандаа нарын нэг болсон сэтгэгдлээ хуваалцана уу?

-Миний хоёргүй сэтгэлээр зүтгэсэн ажлын минь үр дүн болов уу. Мөн гэр бүлийнхэн, багш, хамт олны дэмжлэг, туслалцааг онцлох ёстой. Аав, ээждээ маш их талархаж байгаа. Хурандаа цол авах гэж буйгаа хэлэхэд аав маань их баярласан шүү. [ЗГМ]



Эрхэм хүндэт генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчид аа, Бэлтгэлд болон чөлөөнд байгаа эрхэм хүндэт ахмад дайчид аа,

Улс, Эх орны маань сүр хүч, эр зориг, сүлд хийморийн илэрхийлэл болсон Та бүхэндээ Монгол цэргийн өдрийн болон орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 97 жилийн ойн баярын мэнд дэвшүүлье.

Бидний өвөг дээдэс эх орныхоо тусгаар тогтнол, газар шороо, хүн ардынхаа амгалан тайван амьдралын төлөө амь нас, алд биеийнхээ алжаалыг умарган тэмцэж ирсэн алдар гавьяаны баатарлаг түүхтэй билээ.

Тиймээс ч монголчууд бид ариун гал голомтоо сахин хамгаалагч, ард түмнийхээ өмөг түшиг болсон цэрэг эрсээ хүндлэн дээдэлдэг нандин уламжлалтай.

Монгол цэргийн олон зууны энэ баатарлаг дайчин уламжлалд 1921 оны Ардын хувьсгалын тэмцэл дунд үүсэн байгуулагдсан орчин цагийн Зэвсэгт хүчний түүх онцгой байр суурь эзэлдэг.

Их жанжин Д.Сүхбаатар тэргүүтний манлайлсан Ардын хувьсгалын их хэрэг нь Монгол түмний олон зууны хүсэл мөрөөдөл, 1911 онд эхэлсэн Үндэснийхээ эрх чөлөөний төлөөх хувьсгалын шууд үргэлжлэл байсан юм.

Энэхүү тэмцэл, тэмүүллийн ялалт одоогоос 97 жилийн өмнөх тэртээ нэгэн өдөр Шивээ Хиагтад суурайтсан ардын хувьсгалын партизануудын сүрлэг уухайгаар эхэлж, улмаар эрэлхэг Монгол цэргүүд Эх орныхоо тусгаар тогтнолыг ертөнцийн чихнээ дуурсган зарласан түүхтэй билээ.

Ардын хувьсгалыг удирдан жолоодсон Монгол ардын нам, Ардын Засгийн газар хувьсгалт ялалтаа бататган бэхжүүлэх, улс орноо батлан хамгаалах зорилго бүхий Ардын журамт цэргийг цэгцлэн байгуулснаар Их жанжин Д.Сүхбаатарын хэлсэнчлэн "Европ байдлаар сайтар сурган боловсрогдсон" орчин үеийн Зэвсэгт хүчний эхлэл тавигдсан юм.

Эрхэм нөхөд өө,

Улс эх орныхоо батлан хамгаалах тогтолцоо, төрийн цэргийн байгуулал, Зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлж шинэ шатанд гаргах нь Монгол төрийн бодлого үйл ажиллагааны нэг эрхэм

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 97 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ



зорилго юм.

Монгол Улсын Засгийн газар улс үндэснийхээ аюулгүй байдал, батлан хамгаалах зорилгыг улс төр, дипломатын аргаар хангахыг эрмэлзнийн зэрэгцээ, төрийн цэргийн байгууллаа хөгжүүлэх, орчин үеийн шинж чанартай цэрэг, арми бүхий батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэх, түүний дотор, мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчинтэй байх, түүнийхээ үүрэг гүйцэтгэх чадавч, боломжийг нэмэгдүүлэх чиг шугамыг тууштай баримталж, бие бүрэлдэхүүний мэргэшил, зэвсэглэл, техникийн шинэчлэл зэрэг Зэвсэгт хүчний хөгжлийн чанарын үзүүлэлтийг нэн түрүүн хангахыг чухалчилж байна.

Цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллын баталгаа, албаа хаах ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх, офицер,

ахлагч нарын орон сууцны хангалт, цалин хөлс, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцооны үр өгөөжийг нэмэгдүүлэх нь батлан хамгаалах тогтолцоо, төрийн цэргийн байгуулал, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны бас нэг чухал зорилт болж байна.

Зэвсэгт хүчин маань манай орны залуу үеийнхний цэрэг эх оронч хүмүүжил, иргэний төлөвшил, бие бялдар, сэтгэл зүйн хатуужил, сахилга хүмүүжлийн сургууль байсаар ирсэн.

Монгол цэргийн эрхэм дайчид аа,

Монгол цэргийн болон орчин үеийн Зэвсэгт хүчин байгуулагдсан баярын энэ өдөр Эх орон, ард түмнийхээ төлөө алтан амиа өргөсөн баатарлаг эрсийнхээ алдар гавьяаг болон үе үеийн ахмад дайчдынхаа чин сэтгэлийн зүтгэл, бүтээлийг бид эргэн



дурсах ёстой. Хойч үедээ ахмадуудынхаа алдар гавьяа, эр зориг, бахдам сайхан үлгэр дуурайлыг нь хэлж сануулж байх нь бид бүхний эрхэм үүрэг юм.

Ийм учраас Эх орноо батлан хамгаалах ариун үйл хэрэгт залуу нас, эрч хүч, эрдэм боловсролоо харамгүй зориулсан ахмадууд болон одоо цагт албан үүргээ нэр төртэй биелүүлж байгаа нийт албан хаагчдаа Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа дахин талархал илэрхийлж, чин сэтгэлийн халуун баяр хүргэе.

Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхийн бүхий л үед Эх орныхоо аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн найдвартай баталгаа болж ирсэн.

Цаашид ч энэ эрхэм нэр төрөө хадгалж, залуу үеийн хүсэл мөрөөдлийн бодит илэрхийлэл, цэрэг эх оронч үзлийн төв

ундарга, бие бялдар, сахилга хүмүүжлийн том сургууль, хүн ардынхаа өмөг түшиг, улс орныхоо тогтвортой хөгжлийн нэг баталгаа байна гэдэгт итгэлтэй байна.

Зэвсэгт хүчнийхээ эгнээнд багтаж, хүмүүжиж бэлтгэгдсэн цэргийн хүний хувьд миний бие баярын энэ өдөр Та нартаа дахин баяр хүргэж алдар гавьяат Жанжин тугаа үүрд мөнх дээдэлж явахын өлзий хийморьтой ерөөлийг өргөн дэвшүүлье.

Олон зууны баялаг түүхээ, орчин үеийн ололт амжилтаар бататган бэхжүүлж буй манай Зэвсэгт хүчний яруу алдар мандан бадрах болтугай.

Монгол Улсынхаа төлөө зүтгэе

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХУРЭЛСҮХ

Цаг үе

Эмнэлэгт үзүүлэхийн тулд үүрээр босож цаг авч байна

Шүд үзүүлэх цаг авах нь нэлээд хүндхэн бэрхшээл дагуулдаг болжээ

◀1
Одоогоос 10 гаруй жилийн өмнө ердөө нэгхэн эмчид үзүүлэхэд бүтэн нэг өдрийн ажлаа алдсанаа тод санаж байна. Эмнэлэг онгойхоос нэг цагийн өмнө амьхандаа л эрт гарлаа гэж санан 07.00 цагийн үед очиход 10 гаруй хүн хэдийнэ ирсэн байлаа. Ихэнх нь тэтгэврийн насныхан. Ингээд эмч ч ирж, миний өмнөх 10 гаруй хүнийг ирсэн дарааллаар нь үзсээр цайны цаг хүргэсэн. Цайны цаг дуусаж, яг эмчийн өрөөнд орохын даван дээр танил нь гэсээр хэдэн хүн дараалал дайрах гэж оролдов. Өчнөөн цаг хүлээсэн хүмүүс бухимдах нь ойлгомжтой. Энэ мэтээр монголчууд эмнэлгийн үйлчилгээ авч, эмчид үзүүлдэг байсан цаг саяхных.

Тиймээс эмнэлгийн ачаалал, хүнд суртлыг үгүй болгоно хэмээн эрүүл мэндийн салбарын “том” дарга нар цахимаар цаг олгох систем нэвтрүүлсэн. Харамсалтай нь, нэмэгдэхүүний байрыг сольсон ч нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй гэдгийн адилаар их мөнгө зарцуулан байж хийсэн өнөөх ажил амьдрал дээр төдийлэн үр дүнгээ өгсөнгүй.

Иргэд дүүргийн эмнэлгээс үйлчилгээ авахын тулд үүрийн таван цагт босож, хөхөө өвлийн хүйтэнд үүдээ нээгээгүй эмнэлгийн хаалга сахиж сууна. Ялангуяа, сүүлийн жилүүдэд хүүхдүүдийн шүдний өвчлөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор шүд үзүүлэх цаг авах нь нэлээд том асуудал дагуулдаг болсон. Баянзүрх дүүргийн 25 дугаар хорооны иргэн Б.Бат-Эрдэнэ “Он гарсаар хүүхдийнхээ цоорсон гурван шүдийг эмчлүүлэх гэж гурван удаа хонож дугаарласан. Нэг шүдийг гурав хоног эмчилдэг юм байна. Дараагийн шүдийг нь үзүүлэхийн тулд дахиад заавал цаг авах ёстой. Уг нь шүдний гурван эмчтэй. Саяхнаас нэг эмч нь амралтаа авчихсан. Ариутгасан багаж нь хэмжээ хязгаартай учир өдөрт 30 хүнд л үзлэг, эмчилгээ хийдэг гэсэн. Тиймээс боловсон хүчин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээ нэмчихвэл асуудал шийдэгдэнэ. Миний мэдэхээр гурван жилийн турш манай дүүргийн иргэд хонон онжин дугаарлан байж



С.Батсайхан / ЗГМ

эмнэлгийн үйлчилгээ авч байна” гэв.

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүд кабинетээс шалтгаалан өдөрт 30-50 хүнд эмчилгээний цаг тараадаг аж. Харин өдөрт нэг эмчид хамгийн багаар тооцоход 100 хүн үзүүлэхээр ханддаг байна. Тиймээс иргэд 30 хүнийх нь тоонд багтахын төлөө “Хэн хамгийн эрт босох вэ” хэмээх “марафонд” оролцож, өглөө эртлэн босохоос аргагүй байдал хүрдэг.

● **Эмнэлгийн ачаалал, хүнд суртлыг үгүй болгохын тулд цахимаар цаг олгох системийг нэвтрүүлсэн.**

● **Гэсэн ч нэмэгдэхүүний байрыг сольсон ч нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй гэдгийн адилаар төдийлэн үр дүнд хүрсэнгүй.**

● **Иргэд дүүргийн эмнэлгээс үйлчилгээ авахын тулд үүрийн таван цагт босож, хөхөө өвлийн хүйтэнд үүдээ нээгээгүй эмнэлгийн хаалга сахиж байна.**

Монгол Улсын эрүүл мэндийн

салбарын үйлчилгээ иргэдээ чирэгдүүлсэн, төөрөгдүүлсэн, бүр залхмаар байхад хүн бүр анхан шатны, наад захын эмчилгээ, үйлчилгээ, шинжилгээ өгдөг “эрүүл монгол” болох мөрөөдөл дэндүү хол санагдана.

Техник технологийн үсрэнгүй хөгжилд хүрсэн өнөө үед иргэдийг залхаан цээрлүүлж буй мэт дундад зууны үеийнх шиг ийм үйлчилгээг шийдчихэж болмоор л санагдах юм. Байр цахилгааны төлбөр, торгууль гэх мэт төрийн үйлчилгээг цахимаар төлж болоод байхад эмнэлгийн цаг олгох үйлчилгээг яагаад цахим хэлбэрт шилжүүлж болохгүй гэж. Тухайлбал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн бөөрний хөгжилд хүрсэн өнөө үед иргэдийг залхаан цээрлүүлж буй мэт дундад зууны үеийнх шиг ийм үйлчилгээг шийдчихэж болмоор л санагдах юм. Байр цахилгааны төлбөр, торгууль гэх мэт төрийн үйлчилгээг цахимаар төлж болоод байхад эмнэлгийн цаг олгох үйлчилгээг яагаад цахим хэлбэрт шилжүүлж болохгүй гэж. Тухайлбал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн бөөрний хөгжилд хүрсэн өнөө үед иргэдийг залхаан цээрлүүлж буй мэт дундад зууны үеийнх шиг ийм үйлчилгээг шийдчихэж болмоор л санагдах юм.

Ядахдаа л бүх дүүргийн нэгдсэн эмнэлэг, амбулатори, төвүүдээ цахим хэлбэрт шилжүүлмээр байна. Зөвхөн үзүүлэх өдөр нь заавал цаг авдаг бус даваа гарагт очсон хүнд



хоёр, гурав хоногийн дараах цаг олгодог байх зохицуулалтыг хэрэгжүүлж болмоор. Улсын нэг, хоёр, гуравдугаар төв эмнэлгүүд яг ийм шийдлийг нэвтрүүлж, цаг олголтлоо цахим хэлбэрт оруулсан. Энэ нь сайн болон саар талтай байгааг иргэд хэлж байна. Учир нь цаг авах гэхээр бараг нэг, хоёр сарын дараах цаг байгааг хэлдэг. Ямар л өвчтэй хүн нэг, хоёр сар хүлээх билээ.

Мөнгө төгрөг, бэл бэлчин муутай нэгэн нь таарсан цагийг нь авахаас өөр боломжгүй л байдаг. Тиймээс яаралтай үзүүлэх ёстой өвчтөн, хэд хоногийн дараа үзэж болох өвчтөнийг ялгаж салгаж, эмнэлгийн цаг олгох үйлчилгээг улам илүү боловсронгуй болгох шаардлага байна.

Талхны мөнгөө бүтэн өгчихөөд дэлгүүрээс тал хагас талх авч байгаатай л адил

эрүүл мэндийн даатгал төлж байж эмнэлгийн үйлчилгээг авч чадахгүй байна гэдэг үнэндээ эмгэнэл юм.

Тэртээ тэргүй дүүргийн эмнэлгүүд бүгд цахимд холбогдож, цаг тараадаг болсон учир технологийн шийдлийг төрийн үйлчилгээтэй хослуулж, хүнд суртлыг ор үндсээр нь арилгах шаардлагатай байна. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД

Шарлагын төлөвлөлтийн аппарат ирэх долоо хоногоос хэвийн ажиллаж эхэлнэ


Г.Төгс
ЗГМ

Хавдар судлалын үндэсний төвийн Туяа эмчилгээний гурван хэмжээст төлөвлөлтийн аппаратад гарсан гэмтлийг засахаар болжээ.

Эрүүл мэндийн яамны Тонг төхөөрөмжийн хэлтсийн Эм үйлдвэрлэх технологийн газрын ахлах мэргэжилтэн Н.Гэрэлт-Од “ХСҮТ-ийн Туяа эмчилгээний гурван хэмжээст төлөвлөлт хийдэг аппаратад гарсан гэмтлийг засахад шаардлагатай хөрөнгө болох найман мянган ам.долларыг өчигдөр тус эмнэлгийн дансанд шилжүүлсэн. ЭМЯ-ны зүгээс хөрөнгө мөнгөний асуудлыг шийдэж өгсөн болохоор засварын ажлыг ХСҮТ хариуцан ажиллана” гэв. Харин ХСҮТ-ийн захирал Ж.Чинбүрэн “Манай эмнэлгийн туяа эмчилгээний гурван хэмжээст төлөвлөлт хийдэг

аппаратын удирдлагын системд гэмтэж, засах шаардлагатай болсон. Иймээс ЭМЯ-нд засахад шаардлагатай байгаа хөрөнгийг шийдвэрлэж өгөх хүсэлт явуулсан. Хариу шуурхай ирлээ. Өнөө маргаашгүй БНСУ-аас аппаратад шаардлагатай сэлбэг хэрэгслийг, мэргэжлийн инженер нь авчирч засаж өгөхөөр болсон. Ирэх долоо хоногт туяа эмчилгээний гурван хэмжээст төлөвлөлтийн аппарат хэвийн ажиллаж эхэлнэ” гэлээ. Мөн тэрбээр тус аппаратад гэмтэл гарч, ажиллагаагүй болсон ч өвчтөнүүдийн эмчилгээ тасалдалгүй хэвийн үргэлжилсэн гэдгийг онцлов. Гурван хэмжээст төлөвлөлт хийдэг энэхүү аппарат нь хавдрын голомтыг орчны тархалт болон үсэрхийлэл өгч болзошгүй бүтцийг нь нарийн тодорхойлж, үүнд тохирсон туяа эмчилгээний талбайг сонгон эрүүл эд эрхтнийг боломжит хэмжээгээр хамгаалах үйл ажиллагааг төлөвлөдөг байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН II улирлын захиалга эхэллээ




ОНЛАЙН ЗАХИАЛГА

- УЛИРАЛД: 5000₮ (62 ДУГААР)
- ХАГАС ЖИЛД: 10 000₮ (124 ДУГААР)
- ЖИЛД: 15 000₮ (248 ДУГААР)



ХЭВЛЭМЭЛ ЗАХИАЛГА

- УЛИРАЛД: 30 000₮ (62 ДУГААР)
- ХАГАС ЖИЛД: 60 000₮ (124 ДУГААР)
- ЖИЛД: 120 000₮ (248 ДУГААР)



ХОСОЛМОЛ ЗАХИАЛГА


(Хэвлэмэл + Онлайн)

- УЛИРАЛД: 32 000₮ (62 ДУГААР)
- ХАГАС ЖИЛД: 65 000₮ (124 ДУГААР)
- ЖИЛД: 125 000₮ (248 ДУГААР)



Та QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт **и-мэйл хаяг** эсвэл **утасны дугаараа** бүртгүүлэн Засгийн газрын мэдээ сониныг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:



2600079789

тоот дансанд мөнгөө тушаана уу.

Үзэл бодол



МОНГОЛ ЯЛНА

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжихийн тулд хувьсгал, реформын шинжтэй өөрчлөлтийг нийлэн хийцгээе. Худалдааны эдийн засгаас үйлдвэрлэлийн эдийн засагт шилжихийн тулд үндэсний үйлдвэрлэгчид хүсэл, зорилгоо нэгтгэн ажиллах цаг болсон.

* * *

Зах зээлийн эдийн засгийг өөрчилж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ёстой.

* * *

Улаанбаатарт ажилгүйдэл өндөр байгаа.

Доод орлого хоёр сая төгрөг байвал Улаанбаатараас Солонгос гэсэн нүүдэл зогсоно. Энэ хэмжээний цалин өгөхийн тулд мега төслүүдийг хөдөлгөх ёстой. Дэд бүтцийн томоохон төслүүд гэхэд л төмөр зам, авто зам, шинээр баригдах хотууд гэсэн төсөл, хөтөлбөрүүд бий. Иймэрхүү 8-10 том төсөл бий. Эдгээрийг хэрэгжүүлэхдээ ажлын байр бий болгож, ажилгүй иргэдээ ажилтай болгох ёстой.

* * *

Үйлдвэрлэлийг дэмжих хуулийг 2015 онд баталснаас хойш бодитоор хэрэгжсэнгүй.

Энэ хууль болон цуг өөрчлөлт орсон Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж чадвал сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны 105 тэрбум төгрөг гэхэд л дотоодын хүнс үйлдвэрлэгчдийг дэмжих мөнгө, тэр хэмжээгээр ажлын байр, цалин болж очих болно. Цэргийн дүрэмт хувцас, гутал, томоохон үйлдвэр аж ахуйн нэгжийн ажлын хувцас, сурагчийн дүрэмт хувцас зэрэг дотооддоо үйлдвэрлэж болоод байгаа барааг гадаадаас авсан албан тушаалтанд хатуу хариуцлага тооцдог болох хэрэгтэй.

* * *

Засгийн газар уул уурхайн өрөөсгөл хамаарал түүнийг дагасан эрсдлийг бууруулж, эдийн засгаа олон тулгууртай болгох, хөдөө аж ахуй, газар тариалангийн экспортыг нэмэгдүүлэхэд анхаарна гэдэг итгэл найдвар бага боловч төрж байна.

* * *

Том үйлдвэрлэл, том төсөл байхгүй бол жижиг, дунд үйлдвэр гэж байхгүй. Том төслүүдийнхээ ханган нийлүүлэлтийг хийж байж л жижиг, дунд үйлдвэрлэл амжилттай хөгждөг жамтай.

* * *

Утааг ажилгүйдэл, ядууралтай хамтад нь харж шийдэх ёстой. Иймээс дагуул хот бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлж иргэдээ байнгын ажилтай, тогтмол орлоготой болгох, хөдөөг хөгжүүлэх, их, дээд сургууль, оюутны дотуур байр, засаг захиргааны зарим нэгж, соёл, шинжлэх ухааны байгууллагуудыг хотоос гаргах шаардлагатай.

Газар гэслээ, Ерөнхийлөгч өө, ажлаа эхлэх үү?

Улс төрд гал асч, эдийн засаг хөлдсөн хэдэн жил ард өнгөрч, энэ өвлийн жавартай хамт ажилгүйдэл, ядуурал арилах ёстой. Ингэж найдахад ч учир бий.

2016 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд Найрамдах намаас нэр дэвшигч Дональд Трамп ялсан нь шинэ цагийн улс төрд содон үйл явдал байлаа. Сонгуулийн өмнөх удаа дараагийн санал асуулгаар америкчуудад хамгийн их үзэн ядагдсан гэгдэж байсан тэрбумтан, бизнесмэн эрхэм дэлхийн хамгийн хүчирхэг улсыг удирдахаар олонхын саналаар сонгогдсон юм. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд улстөрч биш, менежер хүн улсыг хөгжүүлдэг болохыг тэр популист амлалтуудаар бус, бодит үйлдэл, үр дүнгээр баталсан.

2016 оны сонгуулиас хойш АНУ-д шинээр 2.4 сая ажлын байр бий болсон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтэй иргэдийн тоо сүүлийн 45 жилийн доод хэмжээнд хүрч буурав. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн эдийн засагт итгэх итгэл бүх цаг үеийн дээд хэмжээнд хүрч, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр хөрөнгө оруулалт хийж эхлээд байна. “11 сарын өмнө индэр дээр зогсоод америкчуудад амлаж байсан татварын шинэчлэлийг хэрэгжүүлж эхлээд байна. Татвар бууруулах шинэ бодлого Америкийн дундаж давхарга болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хамгийн их дэмжлэг болно... 35 хувь байсан аж ахуйн нэгжийн татварын хэмжээг 21 хувь хүртэл бууруулсан. Ингэснээр АНУ-ын компаниуд дэлхийн бусад компанитай өрсөлдөх боломжтой болно. Тэдгээр компанийн ажилтнуудын жилийн орлого 4000 ам.доллараар нэмэгдэнэ” Энэ мэт иргэд болон бизнес эрхлэгчдийн бэлэнчлэх сэтгэлгээг бус өрсөлдөх чадварыг урт хугацаанд тогтвортой сайжруулж, дэмжихэд чиглэсэн бодлогын шинэчлэлүүдийг бахархалтайгаар зарлаж байлаа. Улстөрчдөөс, бас

бидний сонсож дассан тайлангуудаас ялгаатай нь тэр хийх гэж байгаа төлөвлөгөөний тухай бус, эсвэл хэтийн зорилгын тухай биш, өнөөдөр иргэдийн амьдралд бодитоор хэрэгжиж, тусгалаа олсон үр дүнгийн талаар ярьсан юм. Энэ бол түүний ердөө 11 сарын хугацаанд хийсэн ажил.

Х.БАТТУЛГА, ДОНАЛЬД ТРАМП НАР

БИЗНЕСИЙН ТУРШЛАГАТАЙ

ДУНДАЖ ДАВХАРГА, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС БА ТЭДНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙН ТАЛААР ИЖИЛ ФИЛОСОФИТОЙ

ХЯМРАЛЫН ҮЕД УЛСЫГ УДИРДАЖ БУЙ

ЯДУУРАЛ, АЖИЛГҮЙДЭЛТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ

ТАТВАРЫН БОДЛОГЫН ТАЛААР ИЖИЛ БАЙР СУУРЬТАЙ

УЛСТӨРЧ БИШ

Бидэнд ч өндөр хүлээлттэй байх шалтгаан бий. Эдийн засаг төрийн ордон, эсвэл аль нэг яам, агентлагийн нуруун дээр бус баялаг бүтээгч компаниуд, ажилтай, орлоготой байхын тулд өдөр бүр хөдөлмөрлөж буй татвар төлөгч иргэдийн нуруун дээр тогтдогийг ойлгодог Ерөнхийлөгчтэй болсон нь ингэж найдахын учир юм.

Х.Баттулга албаа авснаас хойш эхний бүтээн байгуулалтын улирал одоо л эхэлж байна. Газар гэсэхтэй зэрэгцээд мега төслүүдээ хөдөлгөх ёстойг тэр эртнээс анхааруулж, сануулж байсан. Авто зам, төмөр зам, дагуул хотууд гээд 8-10 төслийг хөдөлгөж байж жижиг, дунд үйлдвэрлэл, ажлын байр бий болно гэдгийг ч зөв томъёолсон. Монгол Улсын эдийн засгийн онцлог, цаг агаараас шалтгаалсан бизнес, бүтээн байгуулалтын асар богино мөчлөгтэй. Үүнийг өөрийн туршлагаараа мэдэрч, унаж, босож явсан хүний хувьд эрхэм Ерөнхийлөгч та энэ хаврыг алдаж болохгүйг сайн мэдэж байгаа. Монгол Улс хөгжлийн шийдлээ тодорхойлчихсон. Хийж бүтээх цаг үе нь ч ирээд байна. Харин хараахан үр дүн алга. Дөрөвхөн сарын дараа таны албаа авсны нэг жилийн ой болно. Тэр үед бүтээн байгуулалтын улирал бараг л шувтарчихсан байна. Харин тэр үед та ямар тайлан тавих бол?

Хэчнээн төсөл хэрэгжиж, хэчнээн үйлдвэрийн суурь тавигдаж, хэдэн хүн ажилтай болсон байх бол?

Ядууралд нэрвэгдсэн нэг сая иргэнээ ядуурлаас гаргаж, 100 гаруй мянган иргэнээ ажилтай болгож, санхүүжилт, захиалгагүй болж зогссон үйлдвэрүүдээ дахин сэргээж, амласан шигээ арилжааны эдийн засгаас үйлдвэрлэлийн эдийн засаг болгож чадах болов уу?

Эсвэл Австралид үер болж, Ардчилсан Солонгост дахин хориг тавьж, хаа нэгтээ дайн тулаан болж, алтны үнэ тэнгэрт цойлохыг хүлээсэн хэвээр байх болов уу? [ЗГМ]

АМЕРИК НЭГДҮГЭЭРТ

Дундаж давхаргыг дэмжих, дундаж давхаргад хөрөнгө оруулах, коллежийг үнэ төлбөргүй болгож, илүү олон залууст сурч боловсрох боломж олгох, эсвэл илүү хямд өртгөөр коллежийн өрөө барагдуулах боломжийг санал болгох. Эд бол эдийн засгийг бодитоор дэмжих алхмууд гэдэгт би итгэдэг.

* * *

Бидний мөч ирээд байна. Америк мөрөөдлийг биелүүлж, Америк мөрөөдлөөр амьдарч эхлэхэд үүнээс илүү тохиромжтой цаг гэж үгүй.

* * *

Бид авто зам, гүүр, хурдны зам, төмөр зам, усан зам шинээр барина. Үүнийгээ америк сэтгэл зүрхээр, америк хүний хүч хөдөлмөрөөр, америк хичээл зүтгэлээр хийх болно.

* * *

Би татварыг бууруулна. Эдийн засгаа өсгөнө. Өсгөх өсгөхдөө түүхэнд байгаагүй хурдаар өсгөнө.

* * *

Татварыг бууруулснаар дундаж давхарга, жижиг бизнес эрхлэгчдийн нуруу тэнийх болно.

* * *

Цалин буурч, баялгийн тэгш бус хуваарилалт бий болж байгаа нь Америк улс ажлын байраа гадагш алдаад байгаагүй холбоотой. Энэ бол зөвхөн үйлдвэрлэлийн асуудал биш, эдийн засгийг бүхэлд нь хамарсан зүйл.

* * *

Америкчууд сайн сургууль, сайн хөрш, сайн ажил хүсэж байна. Гэтэл дийлэнх тохиолдолд бодит байдал өөр. Улс даяар булшны чулуу мэт тархсан зэвэрсэн үйлдвэрүүд, гэмт хэрэг, гэмт бүлэглэл, хар тамхи. Энэ хядлага яг одоо, яг энд эцэс болно. Өнөөдрөөс эхлээд Америк нэгдүгээрт байх болно.

* * *

Хэрвээ та шаргуу ажилладаг бол, хэрвээ та өөртөө итгэдэг бол, хэрвээ та Америкт итгэдэг бол та юу ч мөрөөдөж болно, та хэн ч болж болно, бид хамтаа юунд ч хүрч чадна.

* * *

Америкийн хөгжил цэцэглэлтийг сэргээж, Америкийн аугаа их хувь заяаг дахин тунхаглах цорын ганц боломж бидэнд олдоод байна.

* * *

Миний засаг захиргаа улс төр болон эдийн засгийн олон асуудлыг өвлөж авсан. Үнэнийг хэлэхэд би эмх замбараагүй үед Ерөнхийлөгч болсон.

Авто

Урин дулаан цагт машинаа хэрхэн бэлдэх вэ



Хүйтний ам цаашилж, урин дулаан цаг айлчлан ирлээ. Энэ бол аялал, амралт идэвхжих үеийн эхлэл. Мөн дулаарахтай зэрэгцэн жолооч нар автомашинаа зохих бэлтгэлийг хийх шаардлагатай болдог. Хаврын улиралд автомашинаа бэлдэхдээ юунд анхаарах ёстойг “Бодиз Автомобил” ХХК-ийн ахлах инженер А.Мөнх-Оргил та бүхэнд зөвлөж байна.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАХ ЗҮЙЛС

Дугуй: Өвлийн улирал дуусаж байгаа энд үед тээврийн хэрэгслийнхээ өвлийн дугуйг зуны дугуйгаар солих нь нэн тэргүүний ажил байх

ёстой. Учир нь зуны дугуйг хийсэн резиний хольц нь өндөр температурын халалтад зөөлрөхгүй, мөн өндөр хурдтай явахад элэгдэх нь харьцангуй бага байдаг. Үр дүнд нь дугуйн өнхрөлтийн эсэргүүцэл багасаж, барьцалдах чадвар сайн болно.

Хөдөлгүүрийн тос: Автомашин үйлдвэрлэгчид хөдөлгүүрийн тосыг 5000 км тутамд солих шаардлагатай гэж зөвлөдөг. Харин Монголын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд хавар, намартаа солих хэрэгтэй. Мөн хурдны хайрцаг болон хүч дамжуулах ангийн тос, гидрийн шингэнээ тогтмол шалгаж байх нь чухал.

Хөргөлтийн шингэн: Хөдөлгүүрийг асаагаагүй хүйтэн үед

шалгаж, дундарсан байвал нэмэх шаардлагатай.

Явах эд анги: Цаг зав гарган засварын төвөөр орж, эд ангийн оношилгоо хийлгэхэд хэзээ ч илүүдэхгүй.

Бусад: Автомашины агаарын бохирдлын татвар, жолоочийн болон тээврийн хэрэгслийн даатгал, автозам ашигласны татвараа төлсөн байх шаардлагатай.

АЯЛАЛ ЗУГААЛГААР ЯВАХЫН ӨМНӨХ БЭЛТГЭЛ

Тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал:

- Нөөц дугуйн хийг тааруулах,
- Домкрат болон дугуйн торцов, ослын тэмдэг, анхны

тусламжийн хайрцаг гэх мэт дагалдах хэрэгслүүд бүрэн байгаа эсэхийг шалгах,

• Автомашины цахилгаан хэрэгсэл/гэрэл, эйр кондейшн гэх мэт/ бүрэн бүтэн ажиллагаатай шаардлага хангаж байгаа эсэхээ шалгах,

• Урин дулаан цагт аялал зугаалгаар явахдаа ус шавар туулах элбэг. Ийм үед аяллаас ирсэн даруйдаа тээврийн хэрэгсэлдээ техникийн үзлэг оношилгоо хийлгэж, явах эд анги, гармошка резин болон хүч дамжуулах ангийн тосоо заавал шалгуулж байгаарай.

ОНЦЛОХ МЭДЭЭ

Цахилгаан машин бүхэн байгаль орчинд ээлтэй биш

О.Анударь

2016 онд дэлхий дахинд нийт 750 мянган цахилгаан автомашин зарагдсан талаар Олон улсын эрчим хүчний агентлаг мэдээллээ. Тус байгууллагаас гаргасан Дэлхийн цахилгаан автомашины тайланд тусгаснаар 2016 онд хоёр сая ширхэг автомашин үйлдвэрлэгджээ. Түүнчлэн цахилгаан автомашины нөөц 2020 он гэхэд 9-20 сая, 2025 он гэхэд 40-70 саяд хүрнэ гэсэн тооцоололтой байгааг уг тайланд онцолсон байна. Дэлхийн улс орнууд бензин болон дизель түлшнээс татгалзаж, аль болох байгаль орчинд ээлтэй арга зам эрэлхийлэхийг зорьж байгаа ч цахилгаан автомашин байгаль орчинд 100 хувь ээлтэй биш аж.

Учир нь тэдгээр автомашиныг хөдөлгөдөг цахилгаан нь дулаан ялгаруулалтыг эрчимжүүлдэг хатуу түлш, цөмийн болон сэргээгдэх эрчим хүчний холимог зүйл байдаг байна. Тиймээс усан цахилгаан станцаас эрчим хүч түгээдэг Норвеги улсын цахилгаан автомашинууд л байгаль орчинд хамгийн ээлтэй байх боломжтой гэж мэргэжилтнүүд онцолж байна.

Нисдэг таксины анхны загвар гарчээ

Нисдэг таксины анхны загвар гарсан талаар Boeing компани мэдэгдлээ. Boeing-ийн гүйцэтгэх захирал Деннис Муйленбург “Нисдэг такси хүмүүсийн бодож байгаагаас ч хурдан хугацаанд хэрэглээнд нэвтэрнэ” гэж онцолсон байна. Түүнчлэн “Агаарын замд шинэчлэлт авчрах өөрөө удирдлагатай нисдэг такси болон дронууд ирэх арван жилийн дотор хэрэглээнд нэвтэрнэ” гэж Деннис Муйленбург хэлжээ. Хэдий тийм боловч Deloitte-ийн хувьд үүнээс өөр тооцоолол гаргаж байна.

“Зорчигчдыг нисэх буудал руу хүргэх нисдэг такси ирэх хоёр жилийн дотор буюу 2020 онд зах зээлд нэвтэрнэ” гэж Deloitte-ийн судалгаанд онцолжээ. Харин салбарын мэргэжилтнүүд “Хэрэв нисдэг такси зах зээлд нэвтэрвэл агаарын замын хөдөлгөөний шинэ дүрэм, зорчигчдын аюулгүй байдал гэх зэрэг асуудлыг нухацтай авч үзэх ёстой” гэв.

МЭДЭХЭД ИЛҮҮДЭХГҮЙ

Цахилгаанжилтаас сэргийлж болно

Автомашинаа суух гээд бариулдаа хүрэхэд час гээд л тогтонд цохиулах тохиолдолтой олон жолооч учирсан байх. Ялангуяа өвөл хүн бүхэнд тохиолддог үзэгдэл. Тийм ч сайхан зүйл биш. Цахилгаанжилт юунаас болж үүсдэг, түүнээс урьдчилан сэргийлэх аргуудыг тантай хуваалцъя.

Бүх эд зүйлд байдаг хасах болон нэмэх цэнэгүүд шүргэлцсэнээр цахилгаанжилт үүсдэг. Ялангуяа хуурай агаартай нөхцөлд цахилгаанжилт үүсэхдээ амархан. Автомашинаа суух эсвэл буух

үед цахилгаанжилт хамгийн их үүсдэг. Жолоо барьж байхдаа хөдлөх, суудлаа налах болон хөндийрөхөд хүний биед цэнэг үүсэж байдаг. Харин буух, суух үедээ автомашинд хүрэхэд цэнэг гадагшиж, цахилгаанжилт явагддаг байна.

Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд буух үедээ автомашины төмөр хэсгээс барьж байгаад буух. Суух үедээ эхлээд түлхүүрээрээ автомашиндаа хүрсний дараа бариулаасаа баривал цахилгаанжихаас сэргийлж болно.

Нейлон материал амархан

цахилгаанждаг, хөвөн даавуу гэх мэт байгалийн материалууд бага цахилгаанждаг. Тиймээс нейлон хувцасныхаа дотор талд даавуун хувцас өмсөхийг зөвлөж байна. Хэдий байгалийн материалууд цэнэг хуримтлуулдаггүй ч гутлын хувьд хүндрэл үүсдэг. Ихэнх гутал резинэн ултай бөгөөд резин нь хүний биед хуримтлагдсан цэнэгийг гадагшлуулдаггүй. Хамгийн амархан арга бол гутлын улаа аль болох чийгтэй байлгавал цахилгаанжилтаас сэргийлж чадна.

Cardoctor.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018-03-16

Тендер шалгаруулалтын нэр: Хучилтын температурын хэв гажилтын заадас гагнах ажил.

Тендер шалгаруулалтын дугаар: ЭМГЛ/201802014

“Эрдэнэ Монгол” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Хучилтын температурын хэв гажилтын заадас гагнах

1. Багц-1: 0-60 км-ын хучилтын температурын хэв гажилтын заадас гагнах
2. Багц-2: 60-120 км-ын хучилтын температурын хэв гажилтын заадас гагнах
3. Багц-3: 120-180 км-ын хучилтын температурын хэв гажилтын заадас гагнах
4. Багц-4: 180-239 км-ын хучилтын температурын хэв гажилтын заадас гагнах ажлыг тус тус гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 0 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны жилийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 60%-аас доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Санал болгож буй үнийн дүнгийн 30%-аас доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь:

Санал болгож буй үнийн дүнгийн 50 %-аас доошгүй байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил. (2016, 2017 он) /аудитаар баталгаажсан/

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Бүх төрлийн зам засварын ажил /ЗЗА-1/ гүйцэтгэх зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт

1. Багц-1: 0-60 км 6,662,643 төгрөг
2. Багц-2: 60-120 км 5,768,863 төгрөг
3. Багц-3: 120-180 км 6,496,288 төгрөг
4. Багц-4: 180-239 км 6,514,601 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 10 минутаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 10 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

INVITATION FOR BIDS

Date: 2018-03-16

Project Name: Supple of Fuel products

Project reference No: МШ-2018/096

Mongolian Post company invites sealed bids from eligible Bidders for Supply of Fuel

A complete set of Bidding documents may be obtained by interested eligible Bidders upon submission of written request to the company and payment of a non-refundable fee of Fifty Thousand Mongolian Tugriks (MNT50,000) to the account 2005001080 of the Mongolian Post company of Golomt bank. The Bid shall remain valid for the period of 45 days counting from the day of bid opening.

Bidders shall meet the following key financial qualifications and experiences:

Total revenue: Average revenue of last 2 years must be equivalent to or more than 30 percent of proposed price. (2015 and 2016)

Short term assets and credit ceiling: equivalent to or more than 30 percent of proposed price

Submission of audited financial statements: Last two years (2015 and 2016)

Number of the reference years of similar contractual work experience: Must have an experience of supplying similar equipment at least once in any one of last 3 years.

Bidders must submit a tender guarantee issued by eligible commercial banks authorized for issuing tender guarantees.

Bids must be submitted by at 10:00 am on April 02, 2018 and shall be opened at 10:15 pm on April 02, 2018 at the Conference room

Foreign entity is eligible to submit a tender.

Do not domestic preference will be applied.

Further information and the bidding documents can be obtained from the following address:

Ulaanbaatar, Chingeltei district, Peace avenue, Mongolian Post companies building, second floor, room # 203, Asset management division, contact phone: 99201906
Website: www.tender.gov.mn

Сонирхсон этгээд тендерийн баримт бич

Монгол, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Моннис цамхаг, 14 давхар, мэргэжилтэн Ц.Лхагвадонид
Утас: 75553399, Веб сайт: www.erdnesmongol.mn

ZGM DAILY

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Prime Minister assures to focus on the lack of a policy toward men during the regular session of the National Commission on Gender Equality of Mongolia.

Minister of Defence Enkhbold Nyamaa attends the Doha International Maritime Defence Exhibition and Conference.

ECONOMY

Board Members of Turquoise Hill Resources LLC, an investor of Oyu Tolgoi JSC, meets representatives Sailingstone Capital Partners, 11.49 percent owner of Rio Tinto Group, to discuss corporate governance.

Samsung Galaxy S9 and Galaxy S9 Plus officially enters Mongolian market.

As of March 2018, the number of Mongolian citizens living abroad neared 150 thousand, which is 6 thousand higher than July 2018.

Ulaanbaatar City Governor's Office informs that a total of MNT 51.4 billion will be allocated for Ulaanbaatar city auto road development.

According to Barilga Em En LLC, the average housing price stands at MNT 150 thousand per square meter.

SOCIETY

Mongolian tour operators "Nomadic Journeys", "Bat Tour" are representing the country at the 25th Moscow International Travel and Tourism Exhibition in Moscow.

Mongolian men's team to take part in the FIBA 3X3 Asia Cup 2018 on April 29-May 1 in Shenzhen, China.

Mongolia ranks at 94th from 156 countries on the World Happiness Report 2018.

Development of robotics demand multiple professions from employee

Mechatronic engineers to be prepared in Mongolia

Tugsbilig.B
ZGM

Preceded from the era of electronics and information technology, the Fourth Industrial Revolution, best regarded as the digital revolution, has been cultivating almost every industry in every country since the middle of the last century. As stated by Klaus Schwab, the First Industrial Revolution used water and steam power to mechanize production. The Second used electric power to create mass production. The Third used electronics and information technology to automate production. Now, the Fourth Industrial Revolution is fusing the technologies that is blurring the lines between the physical, digital, and biological spheres.

Amid the ever-changing world that is advancing towards automation and global interconnectivity, Mongolia is taking a step towards the inevitable transformation. Several companies have adapted innovative ideas and models that could reshape the industry; for instance, Mongol Basalt LLC's basalt stone extraction technology and nanofibers of Best Buidan LLC. However, the policy makers, producers and innovators agree that the industrialization 4.0 will require more vocational workers and engineers. This will increase demands for professions based on mathematics, chemistry and physics, as well as educational system reform. Presently, only one-fifth of high school graduates pursue vocational education, which is highly insufficient for keeping up with the fast-changing environment. In addition, the large use of



Batsaikhan.S / ZGM©

robotics is requiring new forms of collaboration, multidisciplinary studies and hybrid professions from employees. With an aim to accelerate the public adaptation to this rapid revolution, the Vocational Education and Training Partnership (VETP), a project being implemented by the Ministry of Labour and Social Protection of Mongolia and German Federal Ministry for Economic Cooperation and Development, held a consultative forum and training yesterday. One of the key goals of the event was to sign a MoU on establishing professional council of mechatronics, one of the

growing field of multidisciplinary studies that combines electronics and mechanical engineering, at the Polytechnic College of Mining Energy (PCME) in Darkhan-Uul Aimag. The signing of MoU confirmed the giant demand for mechatronic engineers as 11 national companies, such as Gobi, Erel and Oyu Tolgoi JSCs, were involved in it. "The demand for mechatronic engineers is very high because the profession will be required in every line of computer-controlled production," highlighted one of the mechatronics teacher of PCME. In terms of either quality or quan-

ty, the VETP project underlined that Mongolia's training market is currently unable to satisfy the technical staff need in mineral resource sector and in the upstream and downstream industries, particularly in electrical, construction and mechanical occupations. This is driven by the lack of studies available for high schoolers that could indicate the labour market trend in the longer-term. Although professional studies are accessible for the young, they are mostly prepared for specified sectors and temporary demand. [ZGM]

Mongolia in need for international standard testing

"In Mongolia, 4.6 percent of the GDP is spent on its education sector. This is a high indicator comparing to other countries of the region," highlighted a press release issued by the World Bank on the occasion of release of a new World Bank report on education sector of the East Asia and Pacific Region yesterday. "However, majority of the expenditure is allocated for variable cost and amount of investment that is made for those such educational materials that are more influential to learning indicators is low in the region," the release continued. It was also noted that it is difficult to compare learning achievement level of Mongolian students because they are not involved in international standard testing.

James Anderson, World Bank Country Manager for Mongolia, stressed that for the country, there is a need to involve in the testing in the future during a press conference called on the occasion. He also noted that Mongolian Ministry of Education, Culture and Science notified that it is planning to involve Mongolian students in some testing starting from 2021

According to the Growing Smarter: Learning and Equitable Development in East Asia and the Pacific report, the East Asia and Pacific region has seven of the top ten performing education systems in the world, with schools in China and Vietnam showing significant progress. "This is a major accomplishment that offers important lessons to countries around the world. In the rest of the region, however, up to 60 percent of students are in under-performing schools that fail to equip them with the skills necessary for success," the report highlighted.

The report argued that improving education is necessary to sustain economic growth and highlights the ways that countries in the region have been able to improve learning outcomes. [ZGM]

SUPPORTED BY:



SPONSORED BY:



ORGANIZED BY:



MEDIA PARTNERS:



MONGOLIA 2018
MINING
INTERNATIONAL MINING & OIL EXPO

4-6 April 2018

**BUYANT UKHAA SPORT'S PALACE
ULAANBAATAR, MONGOLIA**

REGISTRATION OPEN NOW!

Visitors please pre-register at www.mongolia-mining.org to get early access, receive invitation card and badge


www.mongolia-mining.org



THE 8th EDITION

The most important mining show of Mongolia, Attended by the largest number of exhibitors & visitors, Representing the greatest number of countries, Displaying the latest technologies of global mining industry.

☎ 976-11-344 010; 976-9405 3150 ☎ 976-11-343 757 ✉ info@mongolia-mining.org



Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00** "Өглөө" хөтөлбөр
- 10.10** "Зүрхэнд мөнхөрсөн нэр" баримтат кино 1977 он
- 11.00** "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр
- 14.00** "Нууц шифрийн учир" EV төгсгөлийн 9, 10 дугаар анги
- 18.00** "Угтах цагийн аялгуу" хүүхдийн концерт
- 22.10** "Екатерина" олон ангит УСК есдүгээр анги

Bloomberg TV Mongolia

- 07.00** "Суутнуудын намтар" нэвтрүүлэг
- 11.00** #MadeInMongolia. "Ора Металл" ХХК нэвтрүүлэг
- 14.00** "Блумберг форум" нэвтрүүлэг
- 15.00** "Бизнесийн төв цэг" хөтөлбөр
- 20.00** "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
- 21.00** "Мөнгөний урсгал" хөтөлбөр

БОЛОВСРОЛ HD

- 08.05** "Монголчууд ХХ-р зууны эхэнд" нэвтрүүлэг
- 10.00** "4 өнгө" цаг агаарын хөтөлбөр
- 13.00** "Кино миний амьдрал" нэвтрүүлэг
- 20.50** "Хүрээлэн" амьд ертөнц нэвтрүүлэг
- 21.30** "Оргилуун залуу нас" зохиомжит нэвтрүүлэг
- 22.00** "Көсөм" ОАК хоёрдугаар бүлгийн 53 дугаар анги

МОНГОЛТВ

- 06.30** Өнөө өглөө
- 10.30** "Хагачагшгүй дурлал" СОАК
- 12.00** "Хөтөч" мэдээллийн хөтөлбөр
- 14.00** "Хүрээлэн амьд ертөнц" 77 дугаар хэсэг
- 20.00** "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
- 22.30** "Empire" ОАК

ЗУРХАЙ



Билгийн тооллын 29
Хаврын тэргүүн хөх бар сарын гурван хөх мэнгэтэй улаангчин хонь өдөр.
Үс засуулбал: Сүлд тэнэж одно **Наран ургах, шингэх:** 07.05-18.55
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Төрөхүй
Суудал: Огторгуй

Аргын тооллын гуравдугаар сарын 16, Сугар гараг. Билгийн тооллын 29, Чөдөр одтой, улаагчин хонь өдөр.
Өдрийн наран 07.05 цагт мандаж, 18.55 цагт жаргана. Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, лус тахих, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Цөөрөм байгуулах, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой.



"Сарыг нуусан саваагүй бэлтрэг"
Хэзээ: 2018.03.20-ны 11.00, 14.00, 16.00 цагт
Хаана: Хүүхэлдэйн театр
Тасалбарын үнэ: ₮5000



"Нарны хаан хүүхдүүд" тоглолт
Хэзээ: 2018.03.21-ний 11.00, 14.00, 16.00 цагт
Хаана: Хүүхэлдэйн театр
Тасалбарын үнэ: ₮5000



"Адууны түүх" сонгодог жүжиг
Хэзээ: 2018.03.21-ны 19.00 цагт
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮15-25 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

Номхон далайн бослого удахгүй дэлгэцнээ



Бослого дахин эхэлж, Стакер Пентекостын хүү Жэйк Пентекост болон Мако Мори нар нэгдэн шинэ үеийн жолоодогчдыг удирдаж, хувьсан өөрчлөгдсөн хүчирхэг Кайжу мангасуудтай тулалдахад бэлэн болжээ. Залуу жүжигчин Жон Боегатагийн гол дүрд нь тоглосон "Pacific Rim Uprising" буюу "Номхон далайн бослого" кино гуравдугаар сарын 23-нд нээлтээ хийхээр

зэхэж буй. Нийт 111 минут үргэлжлэх уг киног 150 сая ам.доллараар бүтээсэн байна. Жэйк Пентекостын эцэг, Жеймс Пентекост хүн төрөлхтний төлөө Кайжу мангасуудын эсрэг тулалдаж, амиа өгсөн юм. Гэвч Кайжугийн мангасууд усталгүй, хүү Жэйк Пентекостын үед дахин гарч ирж, дэлхийн өнцөг булан бүрт амьдрах хүн төрөлхтөн рүү халддаг. Ингээд Жейк

аавынхаа ажлыг үргэлжлүүлж, дайны сүүдэрт өссөн шилдэг нисгэгчдийн шинэ үеийг тэргүүлэх болно. Ингээд тэд шударга ёсыг эрэлхийлж мангасуудын эсрэг бослогод хамтдаа тулалдсанаар хүчирхэг хамгаалалт болж аймшигтай, гайхамшигтай адал явдлыг туулдаг. Тус киноны зохиолыг Трэвис Бичем бичиж, найруулагчаар Стивен ДиНайт ажилласан байна. [ЗГМ]



Б.Асафьев "Бахчисарайн оргилолт булаг"
Хэзээ: 2018.06.23-24 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга




"Цэргийн бодол" тоглолт
Хэзээ: 2018.03.17-ны 19.00 цагт
Хаана: УБ палас
Тасалбарын үнэ: ₮30 мянга



"Алсын газрын зэрэглээ" концерт
Хэзээ: 2018.03.27-ны 19.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮30-40 мянга

ЗГМ. ҮГИЙН СҮЛЖЭЭ



- Сүмогийн их аваргын хувьчилж авсан цирк
- Гавьяат хуульч, улсын харцага агсан
- Уй, уйтгар
- Афганистан улсад буй монгол үндэстэн
- Маш, тун, асар
- Зан, ааль

- Богино
- Сүүдэр ший
- Хүн төрөлхтөн удахгүй

- айлчлахаар эзэх буй гараг
- Төрийн шагналт хөгжмийн зохиолч
- Г.Бирваагийн зохиосон морины тухай алдарт дуу

Өмнөх дугаарын хариу / 03.15



БОСООГООР.


- Нүүдэлчин монголчуудын эртнээс хэрэглэж ирсэн түлш
- Шатарт хүүгээр мэдлэх нь

ХӨНДЛӨНГӨӨР.


- Эр, эмээрээ тусдаа ургадаг, хоёр гэрт ургамал (жимс)
- Дундговь аймгийн сум

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	III.16	III.17	III.18	III.19	III.20
	4° -11°	6° -9°	7° -6°	6° -4°	8° -3°
	6 м/с 5 м/с	6 м/с 5 м/с	6 м/с 5 м/с	7 м/с 5 м/с	7 м/с 6 м/с
	Үүл багасна	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Ялимгүй хур тунадас	Үүлшинэ



ЗГМ: КОМИК



ЗГМ. СУДОКУ

			1						4
			9	8	6				
7	1	5							
3	9	7							
							8		
			1	6	7	3		5	
8				6			4		1
1	5						2		8
			3				5		

1	8	4	9	5	7	2	6	3
7	6	2	4	8	3	5	9	1
3	5	9	2	6	1	7	8	4
9	7	1	5	3	6	8	4	2
6	2	8	1	4	9	3	5	7
4	3	5	8	7	2	9	1	6
5	9	6	7	2	4	1	3	8
2	1	3	6	9	8	4	7	5
8	4	7	3	1	5	6	2	9

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-СУХБААТАР	21.15	05.12
СУХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
УБ-ЗҮҮНХАРАА	17.30	21.45
ЗҮҮНХАРАА-УБ	04.25	08.40
САЙНШАНД-УБ	20.25	07.01
УБ-САЙНШАНД	09.15	19.15
УБ-МОСКВА	13.50	14.28

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-ЭРХҮҮ	09.00	10.30
ЭРХҮҮ-УБ	11.30	13.00
УБ-ХӨХ ХОТ	13.30	16.00
ХӨХ ХОТ-УБ	17.00	19.40
УБ-МАНЖУУР	14.40	16.40
МАНЖУУР-УБ	17.20	19.55

Syndicated articles from FINANCIAL TIMES

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Гадаадад орон сууцтай болохын тулд хууль зөрчих нь

Бээжин хориглосон ч хятадууд 2017 онд гадаадад орон сууц худалдаж авахад 40 тэрбум ам.доллар зарцуулжээ. > 10

Японы цалингийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрсэнгүй

Ажилчдын цалин 2017 оныхоос илүү өссөн ч Засгийн газраас төлөвлөсөн хэмжээнд хүрч чадсангүй. > 10

Оросын 23 дипломатчийг албадан гаргана

НҮБ дахь АНУ-ын төлөөлөгч Никки Халей Москвад хандаж, мөрдөн байцаалтад туслахыг уриалжээ. > 10



142 тэрбум ам.долларын хэлцэл зогслоо

Ноён Трамп наймаа эцэслэн тохиролцооноос өмнө хориг тавьсан нь АНУ-ын компаниудын хүрээнд шуугиан дэгдээж АНУ-ын Ерөнхийлөгч үндэсний аюулгүй байдлаар түрүү барин протекционист бодлогоо хэрэгжүүлж байна гэсэн айдас дагуулав.

Сүүлийн хэдэн долоо хоногт ноён Трамп “Америк эн тэргүүнд” бодлогоо хэрэгжүүлэхэд бүх хүчээ дайчиллаа. Тэрбээр АНУ-ын үйлдвэрлэл, ажлын байрыг хамгаалах, гаднын компаниудыг дарамтлахад чиглэсэн арга хэмжээ болгон хөнгөнцагаан, гангийн импортод тариф тогтоов.

Broadcom нь Qualcomm-ыг худалдан авсан тохиолдолд АНУ-ын компанийн судалгаа, хөгжүүлэлтэд урт хугацааны хөрөнгө оруулалт багасах аюултай хэмээн АНУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын хорооноос (CFIUS) Ерөнхийлөгчид зөвлөв.

Qualcomm-ыг худалдан авснаах дараа Broadcom “АНУ-ын үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж арга хэмжээ” авч болзошгүй хэмээн ноён Трамп дээрх хорооноос зөвлөгөө авснаах дараа тайлбарлав.

Broadcom ялагдал хүлээсэн ч албан ёсны төвөө Сингапураас АНУ-д шилжүүлэх төлөвлөгөөтэй хэвээр байна. Тус компани хагас дамжуулагчийн тусдаа наймаагаа зогсоох тохиолдолд төвөө шилжүүлэхээр жилийн өмнө АНУ-ын Засгийн газартай тохиролцсон юм.

Broadcom хамгийн сүүлд нэгж хувьцаанд 79 ам.доллар санал болгосон нь Сан Диегод байрладаг компанийг дутуу үнэлсэн хэрэг хэмээн Qualcomm маргаж байжээ. Уг наймаа монополийн эсрэг ноцтой эрсдэл бүхий ажиллагаа хэмээн АНУ-ын чип үйлдвэрлэгч мөн тайлбарласан.

Цахим бизнест оруулсан хөрөнгө ашигтай байна

Хавиер Эспиноза

Дэлхийн томоохон худалдан авалтын сангууд ашиг ихтэй цахим аюулгүй байдлын салбарт хөрөнгө оруулж байгаа. Гэвч хөрөнгийн үнэ өссөн учир худалдан авалтаа үргэлжлүүлэхэд хүндрэлтэй болж эхэлжээ. 2016 онд хувийн хувьцааны TPG сан цахим аюулгүй байдлын программ хангамжийн McAfee компанийн хувьцааны багц худалдан авсан нь ийм хэлцүүдийн томоохонд тооцогддог. Бусад сан хөрөнгө оруулагчдынхаа хөрөнгийг арвижуулахын тулд цахим аюулгүй байдлын зөвлөгөө өгдөг компаниудыг худалдан авах шинэ арга замыг ашиглаж байна. Хоёрдугаар сард хувийн хувьцааны BlackRock, Ramplona группүүд фишинг луйвраас сэргийлэх талаар сургалт явуулдаг PhishMe-ийг худалдан авчээ. Салбарт зөвлөгөө өгдөг компаниудыг худалдан авснаар хувийн хувьцааны фирмүүд түргэн өсөж буй аж үйлдвэрээс хохрохгүйг хичээж байгаа. Гэвч дорхноо хуучирдаг аль нэг технологийг дэмжихээс зайлсхийж байна.




Энэ стратеги хөрөнгө оруулагчдад хааяа асар их ашиг авчирдаг гэж хэлцүүдийг мэдэх хүмүүс ярьжээ. Гэвч салбарын шинжээчид ярихдаа тус салбарын ирээдүйг бусад нь ойлгохын хэрээр компаниудын үнэ өсөж, хөрөнгийн менежерүүд урьдын амжилттай стратегийг давтахад бэрхшээлтэй болж буйг анхааруулав. Сүүлийн жилүүдэд хэрэглэгчдэд учирсан цахим заналхийлэл нэмэгдэж, цаашид өсөх хандлагатай байгаа тул Carlyle, Blackstone мэтийн сангууд өсөлтийн боломжид суурилан хөрөнгө оруулсаар байгаа юм. Өнгөрсөн онд мөнгө төлөх хүртэл хэрэглэгчийн өгөгдлийг кодлодог WannaCry хэмээх барьцаа шаардсан программ дэлхийн 100 шахам оронд тархаж, Орос, Британи, Хятад зэрэг улсад 45 мянга тохиолдол бүртгэгдсэн. Уг дайралт аль нэг байгууллагыг

чиглээгүй бөгөөд программыг татаж авсан хүмүүсийг онилсон байна. Түүнчлэн нэгдүгээр сард Apple компани iPhone, iPad болон тэдний бусад бүтээгдэхүүнийг эзэмшигчид хакарын дайралтад өртөх эрсдэл байгааг хүлээн зөвшөөрсөн нь ийм аюул хэр зэрэг өргөн тархсаныг харууллаа. Гэхдээ антивирус хийдэг компанийг худалдан авахын оронд салбарын зөвлөх компаниуд руу хараагаа чиглүүлж байна гэж Blackstone-ы ахлах гүйцэтгэх захирал Мартин Брэнд хэлсэн юм. Гэхдээ цахим давсны дараа өнгөрсөн онд таамгаа хоёр удаа дээшлүүлсэн. 2017 оны эхний хагаст янз бүрийн

хакарын дайралтын улмаас тэдний үйлчилгээг авдаг компанийн тоо нэмэгдсэн аж. Түүнчлэн өнгөрсөн онд Blackstone-ы орлого нэмэгдсэн нь үндсэндээ Optiv Security дэх хувьцааны багцаа өрсөлдөгч KKR компанид зарсан ашгаас шалтгаалсан байна.



Нью-Йоркт төвтэй хувийн хувьцааны энэхүү аварга компани “худалдаж аваад босго” гэсэн стратегийг баримталдаг. Энэ нь нэг компанийг худалдан аваад өрсөлдөгчтэй нь нэгтгэж, тэргүүлэх бизнес босгосноор өртгийг танах арга юм. Blackstone 2014 онд зах зээлийн таван хувийг эзэлж байсан Accuvant компанийг худалдан авчээ. Дараахан нь бас л зах зээлийнхээ таван хувийг эзэлдэг FishNet-ийг авсан байна. Тэднийг нэгтгэсэн Optiv хэмээх шинэ компани салбартаа ноёрхох болсон байна. “Хоёр дахь хамгийн сайн сонголт нь зах зээлийн ганцхан хувийг эзэлдэг” хэмээн ноён Брэнд ярилаа. Тус компанийн таамагласан орлого 2011-2016 онуудад жил бүр 20 хувиар өсөж байжээ. Мөн хугацаанд хүү, татвар, ханшийн өөрчлөлтийг хасаад ашиг нь 40 хувь өссөн явдал бизнесийнхээ хувьцааг гаргах хөшүүрэг болсон юм.

Азийн хувийн хэлцлүүд дээд хэмжээнд хүрлээ



Дон Вейланд

Bain & Company фирмийн тайланд Азид хувийн хувьцааны хэд хэдэн мега хэлцэл хийгдсэний үр дүнд 2017 онд дээд хэмжээ буюу 159 тэрбум ам.доллар хүрч өмнөх оноос 41 хувь өссөнийг онцлов. Bain Capital компани Toshiba-гийн чипний бизнесийг 18 тэрбум ам.доллар, Хятадын консорциум Сингапурын Global Logistic Properties-ийг худалдан авсан зэрэг өнгөрсөн оны томоохон хэлцлүүд Азийг хувийн хувьцааны хэлцлийн дэлхийн халуун цэг болголоо. Тус тайланд дурдсанаар нийт хэлцлийн 60 хувийнх нь ард дэлхийн томоохон фирмүүд байсан агаад хэлцлийн 70-аас дээш хувь нь нэгээс дээш тэрбум ам.долларын өртөгтэй байв. Хэлцлийн тоо ийнхүү эрс өссөний нэг шалтгаан нь бизнес эрхлэгчид хувийн хувьцааг худалдах эрмэлзэл дээшилснээс үүдэлтэй гэж Bain & Company дүгнэв. Азийн олон компанид үе солигдож, тухайлбал үүсгэн байгуулагчид залуу үеийнхэндээ хяналтыг худалдахад хүргэж байгаа аж. 2017 онд технологи ба интернэтэд төвлөрсөн бизнес хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан бөгөөд нийт хэлцлийн өртгийн 46 хувийг эзэлсэн байна. Хятадын зах зээл хамгийн идэвхтэй байж, өнгөрсөн онд 570 хэлцэл бүртгэгджээ.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Шанхайд арванхоёр-дугаар дугаар сард болсон тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийн яармаг олон мянган чинээлэг худалдан авагчдын анхаарлыг татав.



Гадаадад орон сууцтай болохын тулд хууль зөрчих нь

Юань Ян, Эмили Фэн

Хятад иргэд үл хөдлөх хөрөнгө худалдан авахаар мөнгөө хилийн чанадад гаргах нь онолын хувьд хууль бус үйлдэл. Гэвч Хятадын хотуудад зохиогддог олон улсын үл хөдлөх хөрөнгийн яармагт шавсан хүмүүс үүнийг ойлгоход тун хэцүү.

Хамгийн сүүлд Шанхайд болсон арга хэмжээнд 12 мянга гаруй худалдан авагч цугларчээ. Харин Бээжинд болсон яармагийг бизнесийн төв дүүрэг дэх таван одтой зочид буудалд зохион байгуулсан.

Яармаг Манчестерт оюутны орон сууц, Лондоны Баттерси цахилгаан станцын барилгад өрөө зарах, АНУ, Их Британи, Грект хөрөнгө оруулагчийн виз гаргаж өгөх агентуудаар дүүрэн байлаа. Хоёр дахь наймаагаа хийж орхисон зарим худалдан авагч анхны наймаагаа хийх гэж буй анд нөхөр, хамаатан садан, бизнесийн түншээ авчирчээ.

Хятадаас мөнгө гаргах хэцүү болсон ч сүүлийн гурван жилд Бээжингийн яармагийн цар хүрээ хоёр дахин томорсныг тус яармагийг үндэслэгч Оливье де Трегло тайлбарлав. “Хятадын хуулийг аргалах арга хэзээд олдоно” хэмээн АНУ дахь үл хөдлөх хөрөнгийн арилжаанд зуучилдаг Бээжингийн хөрөнгө оруулалтын компанийн менежер ярьж байлаа.

Юанийн ханшийн уналтыг зогсоох үүднээс БНХАУ 2016 оны эцсээс хөрөнгийн гадагш урсгалд хатуу хяналт тогтоожээ. Жилийн өмнөөс Хятадын

банкууд валют солиулж буй үйлчлүүлэгчдээ зөвхөн албан ёсоор зөвшөөрсөн наймаанд мөнгөө зарцуулах амлалтад гарын үсэг зуруулдаг болсон. Уг зөвшөөрөлд үл хөдлөх хөрөнгө худалдаж авахыг хориглосон заалт бий.

Хятад дахь олон улсын үл хөдлөх хөрөнгийн худалдааны гол сайтын нэг Juwai.com-ын тооцоогоор тус улсын иргэд 2017 онд гадаадад орон сууц худалдаж авахад 40 тэрбум ам.доллар зарцуулжээ. Уг тоо 2016 оныхоос 25 хувиар бага байгаа. Гэхдээ л 2017 он нь үл хөдлөх хөрөнгийн наймаа Хятадад оргилдоо тулсан гурван жилийн нэг. “Худалдан авагчдын сонирхол урьд байгаагүйгээр ихэссэн. Харин зарим наймаа их хугацаа авдаг болчихлоо” хэмээн АНУ дахь үл хөдлөх хөрөнгийн худалдаагаар мэргэшсэн Шанхайн East-West Property брокерын компанийн ерөнхий менежер Жэй Сяо ярьж байна.

Хятад худалдан авагч нар эрх баригчдын хяналтад өртөхгүйн тулд стратегиа өөрчилжээ. Зарим нь томоохон үл хөдлөх хөрөнгө бусдадтай нийлж худалдаж авахдаа краудфандинг буюу олон нийтийн санхүүжилт ашигладаг. Бээжин хөрөнгийн гадагш урсгалд хяналт тогтоомогч хэрэглэгчдийн идэвх эрс сэргээснийг краудфандинг сайтууд тайлбарлаж байна.

“Хүмүүс АНУ-аас жижиг үл хөдлөх хөрөнгө худалдаж авах нь ихэссэн. Бас эрх баригчдын хяналтаас болоод Тайланд зэрэг улсад хямд хөрөнгө худалдаж

авах нь ч нэмэгдсэн” хэмээн нэрээ нууцалсан онлайн үл хөдлөх хөрөнгийн брокерын компанийн захирал өгүүлсэн юм. “Төлж чадаж л байвал мөнгөө яаж гадагш гаргах нь бидэнд хамаагүй” хэмээн тэрбээр нэмж тайлбарлав. Арилжааных нь 25 хувь хугацаа саатсаныг East-West Property-гийн судалгаа харууллаа. Жишээ нь, 2016 онд гэрээнд гарын үсэг зурснаас хойш төлбөр дунджаар гурваас зургаан сард багтаж хийгддэг байсан бол 2017 онд уг хугацаа зургаан сар гаруй болж уртасжээ.

Эдийн засгийн ашиг харах бус, эх орноосоо алсад амьдрах замаа засаж буй хэрэг болдог учраас гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах нь хятад баячуудын мөнхийн эрмэлзэл.

“Мөнгө гадагш урсахыг харах таагүй ч хүмүүсийн дийлэнх нь үр хүүхдийнхээ эрүүл мэнд, боловсролыг боддог болчихлоо” хэмээн 1000 худалдан авагчид үйлчилсэн хатагтай Сяо ярсан юм. Түүний үйлчлүүлэгчдийн ихэнх нь гадаадад цагаачлах битүүхэн хүсэлтэй. Хятадын чинээлэг иргэд хүүхдийг нь багтраатай болгосон агаарын бохирдол, өөлдөн дэвжих боломж олгохгүй байгаа хөшүүн болхи боловсролын тогтолцоо, байнга хувирдаг нийгмийн зэрэг дэвээс болж албан тушаалаа алдах аюулаас эмээдэг.

Гадаадад цагаачлах эсвэл боловсрол эзэмших нь үр хүүхдийнх нь нийгмийн статусыг бэхжүүлж, илүү тогтвортой нийгэмд амьдрах баталгаа юм.

Цалингаараа амьдардаг дундаж ангийнхангай харьцуулахад элит хэсгийнхэн нэг удаагийн юм уу цаг зуурын завшаанаар баяжигсад байх нь олонтоо. Үүнд нэг удаагийн бизнесийн тохиролцоо, нийгэд хөрөнгөө анх удаа нээлттэй арилжсан, эс бөгөөс үл хөдлөх хөрөнгийн бүүм болсон 1990-ээд оны үед орон сууцны наймаагаар хөлжигсөд багтана.

Хөрөнгөө юунд зарцуулах нь тодорхой. “Хятад хөрөнгө оруулагчдын мөнгөө хийдэг газар цөөхөн” хэмээн БНХАУ-ын иргэдэд хөрөнгө оруулалт, цагаачлалын зөвлөгөө өгдөг Henry Group-ийг үндэслэгч Хэни Жюу өгүүлэв.

Үл хөдлөх хөрөнгийн хөөсийг намжаах хязгаарлалт тогтоосноос хойш дотоодын орон сууцны зах зээл сонирхол татах нь багасав. Хоёр жилийн өмнө хөрөнгийн зах зээл хямрахад хөрөнгө оруулагчид мөнгөө алдсан. Бондын зах зээлийг эрсдэлтэй, зохицуулалт сул хэмээн хүмүүс болгоомжилдог.

Дээрх нөхцөл нь хадгаламж их, эдийн засгийн бүүм удаан үргэлжилж буй улсын иргэд мөнгөө гадаадын үл хөдлөх хөрөнгөд зарцуулах үүд болж өгчээ. “Эд баялаг улам л хуримтлагдаад байна. Тэгэхлээр энэ их хөрөнгө нэг тийшээ хөдөлж л таарна” хэмээн консалтингийн JLL компанийн Ази Номхон далайн бүс хариуцсан судалгаа эрхэлсэн тэргүүн Жо Жюу ярьж байна.

UBS салбараа нэгтгэв

Эмма Данкли

Швейцарын UBS group бизнесээ оновчтой зохион байгуулах зорилгоор Ази Номхон далайн бүс дэх үнэт цаасны болон өрийн хөрөнгийн зах зээл хариуцсан салбараа нэгтгэж байна. Үүнийг тус группийн бүс нутгийн хөрөнгө оруулалтын банкны тэргүүнээс илгээсэн дотоодын санамж батлав.

Хөрөнгө оруулагч болоод бүтээгдэхүүний үүднээс ашигтай тул бизнесийн хоёр салбарыг нэгтгэж буйгаа Дэвид Чин пүрэв гарагийн өглөө ажилтнууддаа илгээсэн зурвастаа дурджээ. Ноён Чин “Хоёр группийг нэгтгэснээр бид илүү сайн үйлчилж, хөрөнгө нөөцийг уян хатан хуваарилах боломжтой болно” хэмээн тайлбарлав.

Нэгтгэх явцад ажлын байр цомхотгохгүй хэмээн зурвас хүлээн авсан банкийн удирдах ажилтны нэг өгүүлж байна.

Орон нутгийн үнэт цаасны зохицуулах байгууллага UBS-ыг Хонконгод 18 сарын турш IPO санхүүжүүлэхийг хориглож, 119 сая хонконг доллараар торгосны

дараа дээрх санамж гарчээ.

Уг хориг нь Хонконгийн биржийн зарим бүртгэлд Швейцарын зээлдүүлэгчийн гүйцэтгэсэн үүргийг мөрдөн шалгах ажиллагааны үр дүн. Давж заалдахаа мэдэгдсэн UBS урьдын адил Хонконгийн IPO-д баталгаа гаргах чадвартайгаа онцлон дурдлаа. Үнэт цаас, өрийн капиталын зах зээлийн бизнесээ нэгтгэх арга хэмжээ нь өнгөрсөн долоо хоногт Хонконгийн үнэт цаас, фьючерсын комиссоор оноосон торгуультай хөлбоогүй хэмээн UBS-ын төлөөлөгч Financial Times-д тайлбарлав. Нэгтгэх ажиллагаагаар Гэзтано Бассолино тус группийн Ази, Номхон далайн хөрөнгийн зах зээл хариуцсан захирлаар дэвшжээ.

Мөнгөн хөрөнгийн зах зээл хариуцсан тэргүүн Хуан Пэйхао тус банкны орхиж буйг мэдээллийн хэргэлүүд таамаглав. Хэвлэлийн таамгийн харид UBS банк хатагтай Хуаныг албан тушаалдаа хэвээр үлдэнэ хэмээн мэдэгдлээ.



Оросын 23 дипломатчийг албадан гаргана

Хенри Манс, Макс Седдон

Их Британид Оросын тагнуул асан этгэдийг хордуулсан хэмээн буруутгаж, хариуд нь Лондон Оросын 23 дипломатыг албадан гаргахаар шийдвэрлээ. АНУ-ын тал уг асуудлаар Британитай бүрэн санал нэгдэж буйгаа мэдэгдэв. НУБ дахь АНУ-ын төлөөлөгч Никки Халей Москвад хандаж, мөрдөн байцаалтад тусласныг уриалжээ. Өмнө нь Британи зарлагчдад тагнуул гэдэг нэрээр Оросын дипломатуудыг гаргаж, Москвагай өндөр түвшний хэлхээ холбоогоо зогсоохоо мэдэгдсэн нь тагнуул Сергей Скрипалыг хордуулсан хэрэгт Орос улс оролцсон гэх сэжиглэлд үндэслэн авч байгаа эхний арга хэмжээ болж байна. Ашигласан хор нь цэргийн зэрэглэлтэй бөгөөд зөвхөн Орост үйлдвэрлэх боломжтой гэж Их Британи үзжээ. Британийн Ерөнхий сайд Тереза Мэй хэлэхдээ тус улс холбоотнуудтайгаа хамтарч, Оросын “төрийн түрэмгийллийн” эсрэг бодлого боловсруулна гэснээс үзэхэд хоёр талын зөрчил олон улсын маргаан болж хувирах магадлалтай. Оросын тал Британийн “урьд үзэгдэгийг бүдүүлэг өдөөн хатгалгыг” буруушаагаад хариу арга хэмжээ авахаа мэдэгдэв. Уг асуудлыг НУБ-ын Аюулгүйн зөвлөлөөр хэлэлцэхэд Британийн төлөөлөгч тус байгууллагын мэргэжилтнүүдийг урьж, бие даасан шинжилгээ хийлгэхийг санал болгожээ.

Европын зөвлөлийн Ерөнхийлөгч Дональд Туск уг асуудлыг ирэх долоо хоногт зөвлөлийн хурлаар авч хэлэлцэхээ мэдэгдлээ. Хатагтай Мэй төлөөлөгчдийн танхимд хэлсэн үгэндээ “ОХУ-ын сүүлийн үйлдэл хууль зүйг суурилсан олон улсын журмыг өгч тоох тус улсын хандлагын нэг илрэл. Мөн дэлхийн улсуудын тусгаар тогтнол аюулгүй байдлыг буснуулах ба өрнөдийн ардчилсан байгуулалт, үйл явцыг гутаах, сүйтгэх оролдлого мөн. АНУ манай холбоотнууд, түншүүдтэй хамтран ийм жигшүүрт халдлагыг дахин гаргахгүй байх талаар ажиллаж байна” гэжээ. Өнгөрсөн долоо хоногт Скрипал ба түүний охиныг хордуулсан явдалд Британийн өгч буй хариу 2006 онд Оросын тагнуул байсан Литвиненкогийн амийг хөнөөсөн хэргийнхээс хавьгүй түргэн бөгөөд өргөн хүрээг хамарч байна. Албаныхан ярихдаа Оросын дөрвөн дипломатчийг албадан гаргасан боловч хэрэг явдлыг сунжруулах Москвагийн тактикаас сургаж авсан гэжээ. Мэйгийн авсан арга хэмжээ 30

жилд хамгийн өргөн хүрээтэй бөгөөд Британи дахь Оросын тагнуулын албаны чадамжийг эрс доошлуулж байгаа аж. Гэхдээ 23 хүний тоонд оюутан, сэтгүүл болон Оросын банк, компаниудын ажилтнуудыг багтааж магадгүй гэнэ. Их Британийн Ерөнхий сайд түүнчлэн энэ жил Орост болох Дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд хатан хааны гэр бүлийн гишүүд оролцохгүй гэж мэдэгдээд Оросын Гадаад хэргийн сайд Сергей Лавровт илгээсэн айлчлалын урилгыг цуцалснаа мэдэгджээ. Оросын тал ноён Лавров урилгыг хүлээн аваагүй гэв. Британийн Засгийн газар түүнчлэн дайсангагч улсын зүгээс явуулж болзошгүй бүх хэлбэрийн үйлдлийн эсрэг хууль боловсруулж, ийм үйлдэлд сэжиглэгдсэн хүмүүсийг хил дээр саатуулах заалт тусгахаар төлөвлөж байна. Дотоод хэргийн яам сөрөх тагнуулын шинэ алба байгуулах асуудлыг хэлэлцэж, Засгийн газар Америкийн Магнитскийн хуультай адил хүний эрхийн зөрчилд оролцсон хүмүүст хориг тавих тухай хуулийн төсөл санаачлахаар шийдвэрлэжээ.

Британийн Батлан хамгаалахын сайд Гэвин Уильямсон химийн зэвсгээс хамгаалахад зориулж, 48 сая паундыг Портон Даун дахь химийн лабораторид олгохоо өчигдөр зарлалаа. “Эдгээр хориг Оросын мөнгийг Лондоноор дамжуулан саадгүй угаагж байгааг саатуулах өмнөх арга хэмжээн дээр нэмэгдэнэ” гэж албаны хүн тайлбарлав. Орос, Британийн харилцаа Украин, Сирийн улмаас хэдийн хурцаад байсан авч энэхүү зэрэг явдлаас болж, улам дорджээ. НАТО-гийн орнууд Британийг дэмжихийн сацуу 1949 онд тус эвсэл байгуулагдсанаас хойш анх удаа гишүүн улсын нутаг дэвсгэр дээр химийн бодисыг дайралтын зорилгоор ашигласанд сэтгэл түгшнэж буйгаа илэрхийлжээ.

Оросын Аж үйлдвэрийн сайд Денис Мантуров Интерфакс агентлагт өгсөн ярилцлагадаа “Москва Зөвлөлтийн үеийн бүх химийн зэвсэглэлийг устгасан” гээд сая Скрипалыг хордуулсан гэх “Новичок” нэртэй сэтгэлийн бодисыг өнгөрсөн жил үйлдвэрлэлээс хассаныг мэдээлэв. Оросын сөрөг хүчний удирдагч Алексей Навальный хатагтай Мэй Британи дахь Оросын мөнгөний эсрэг авсан арга хэмжээ хангалтгүй гээд “23 дипломатчийг Британиас гаргасан ч Оросын 23 олигархи буюу авлигачид Лондонд зугаацаар үлдэнэ” гэж твиттертээ бичжээ.



Японы цалингийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрсэнгүй

Робин Хардинг, Кана Инагаки

Энэ оны “хаврын дайралт”-ын (тайлбар: жил бүрийн хавар үйлдвэрчний эвлэлүүдээс өрнүүлдэг цалин өсгөх кампанит ажил) үеэр Японы олон компанийн цалин өсгөхөөр боллоо. Гэсэн ч цалингийн өсөлт Ерөнхий сайд Шинзо Абэгийн төлөвлөсөн гурван хувьд хүрч чадсангүй.

Компаниудын удирдлага болоод үйлдвэрчний эвлэлүүдийн хооронд болдог жил тутмын хэлэлцээгээр үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын цалинг 2017 оныхоос илүү өсгөсөн юм. Гэвч цалин Засгийн газрын зорилтот түвшин шиг өссөнгүй. Энэ өсөлт нь инфляцыг хоёр хувьд хүргэх Японы төв банкны зорилтот тааруухан дэмжлэг боллоо. Японы инфляцыг хоёр хувьд хүргэж өсгөхөд олон жил шаардлагатай хэвээр байна.

“Анхны тооцооноос ялимгүй сайн өснө гэж таамаглаж байлаа. Цалингийн инфляц Японы төв банканд тулгараад буй түүхтэй ижил аажуу өсөх нь” хэмээн Токио дахь JPMorgan-ы эдийн засагч Масамичи Адачи

тайлбарлав.

Үйлдвэрлэгч компаниуд их хэмжээний орлого олох тооцоотой ч олон улсын өрсөлдөгчидтэй өрсөлдөх чадвар сулрахаас эмээн ноён Абэгийн гурван хувиар тооцсон зорилтот нийцүүлэхдээ дурамжхан байна.

Nissan сарын цалинг дунджаар 2.4, Hitachi 2.3, Toshiba 2.5 хувиар тус тус өсгөхөөр амлав. Тайванийн Foxconn-ы мэдэлд шилжсэн Sharp гурван хувиар өсгөхөөр боллоо.

Харин Toyota компани үйлдвэрчний эвлэлийн гишүүн 68 мянган ажилчныхаа сарын цалинг дунджаар 3.3 хувиар нэмэхээр шийдлээ. Тус компани жилийн өмнө цалингаа гурван хувиар өсгөж байжээ. Японы автомашины үйлдвэрлэгч болох тус компани урьд нь нийт салбар даяар цалин өсгөдөг байсан юм. Энэ удаад уламжлалаа зөрчсөн тус компани тодорхой тайлбар өгөөгүй ч ханган нийлүүлэгч нар цалин өсгөх шийдвэрийг тусдаа гаргах нь зүйтэй хэмээн мэдэгдэв.

Цахиурын хөндийн компа-



ниудаас шалтгаалан бизнесийн өрсөлдөөн ширүүсэж буйг онцолж буй Toyota-гийн удирдлага, үйлдвэрчний эвлэлийн хоорондох хэлэлцээ сунжирсаар сүүлчийн минутад тохиролцжээ. Мөн цахилгаан хөдөлгүүрт, автомат жолоодлогот автомашин хөгжүүлэх зардал ч өссөөр байна. “Зуунд ганц тохиох шилжилт, чадахгүй бол мөх гэсэн зарчим бүхий өрсөлдөөнтэй тулгарсан бид компани авч үлдэхийн төлөө хөдөлмөр, менежментээ нарийвчлан хэлэлцэж байна” хэмээн Toyota-гийн ахлах гүйцэтгэх захирал Тацүро Үэда

өгүүлсэн юм.

Цалинг ажилласан жилээр тооцож шат ахиулан өсгөдөг учраас компаниудын цэсэн дэх бодит өсөлт албан ёсны статистикаас хоёр хувиар доогуур байж болдог. Эцсийн дүн оны эцсээс нааш гарахгүй. Жишээ нь, 2017 онд цалингийн дундаж өсөлт 1.98 хувь байсныг үйлдвэрчний эвлэлийн “Ренго” холбоо тооцоолжээ. Уг үзүүлэлт нь 2015 онд оргилдоо тулж 2.2 хувьд хүрч байсан бол хоёр жил дараалан буурчээ.



Төв банкны мэдээлэл

БАНК САНХҮҮ

Мөнгө угаалттай тууштай тэмцэнэ

Монгол Улс мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй орны тоонд багтдаг

Г.Байгал
@baigalZGM

Хууль бус үйлдлээс үндэслэж, хууль бусыг тэтгэдэг бохир мөнгө дэлхийн санхүү, эдийн засгийн системийн нэг сорилт хэвээр байна. Тиймээс цэнхэр гараг даяар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэж буй ч технологиор зэвсэглэсэн энэ төрлийн гэмт хэрэг улам нарийн зохион байгуулалттай болж буйг олон улсын байгууллагууд анхааруулж байна. Дэлхийн эдийн засгийн 2-5 хувь буюу ойролцоогоор 4-5 их наяд ам.доллартай тэнцэх хэмжээний мөнгө хууль бус ажиллагааны хэрэгсэл болдог гэсэн тооцоог СЕВ компаниас гаргажээ.

Монгол Улс энэ төрлийн гэмт хэргийн өндөр эрсдэлтэй орны тоонд багтдаг. Basel институтийн танилцуулдаг мөнгө угаах эрсдэлийн индексээр Монгол Улс 149 орноос 51 дүгээрт бичигдэж, ОХУ, Кыргызстан зэрэг улстай хамт өндөр эрсдэлтэй орны нэг болжээ. Монгол Улсад жилд дунджаар мөнгө угаахтай холбоотой 200 гаруй хэрэг бүртгэгддэг. Гэхдээ энэ төрлийн гэмт хэргийг суурь хэрэг гэж тооцолгүй, давхар зүйл ангиар шийтгэдэг байна. Тиймээс одоогоор мөнгө угаах гэмт хэргээр шийтгэгдсэн тохиолдол байхгүй болохыг Монголбанкны



Ази Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг 2016 оны арваннэгдүгээр сард Монгол Улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоог үнэлж, өндөр эрсдэлтэй орон гэж дүгнэжээ.

С.Батсайхан / ЗГМ©

Санхүүгийн мэдээллийн албаны дарга Х.Батчулуун ярилаа.

Санхүүгийн зарчмаас харш, зах зээлд халтай энэ төрлийн гэмт хэргийн эсрэг манай улс олон жилийн өмнөөс тэмцэж эхэлсэн. Гэхдээ өнөө хэр систем нь хэврэг хэвээр байна. Ази Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг 2016 оны арваннэгдүгээр сард Монгол Улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоог үнэлсэн. Тус бүлгээс Монгол Улсыг өндөр эрсдэлтэй тооцож, манай тогтолцоог сайнгүй хэмээн дүгнэсэн байна. Бас одоогийн нөхцөл байдлаа сайжруулах 15 сарын хугацаа өгөөд байгаа аж. 2018 оны аравдугаар сар хүртэл үргэлжлэх энэ хугацаанд багтан манай улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой

хууль эрхзүйн орчноо сайжруулж, олон улсын байгууллагаас өгсөн 40 зөвлөмжийг биелүүлэх учиртай. Хэрэв хугацаа хэтрүүлж, хэрэгжүүлээгүй тохиолдолд Олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага буюу FATF-ийн хар болон саарал жагсаалтад багтах эрсдэлтэй. Энэ нь хэтдээ Монголыг чиглэх гадаадын хөрөнгө оруулалт багасах, зээлжих зэрэглэл буурах зэрэг сөрөг үр нөлөөг дагуулж болзошгүй.

Хууль бус мөнгөний эргэлтийг хумих энэ шинэчлэлийн хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. 2013 онд баталсан энэ хуулийн шинэчилсэн төслийг УИХ-д өргөн бариад

байгаа бөгөөд ирэх хаврын чуулганаар хэлэлцэх товтой байна. Шинэчилсэн төсөлд энэ төрлийн гэмт хэргийг мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн хүрээг улам тэлжээ.

Монголд жилд мөнгө угаах магадлалтай 200 гаруй хэрэг бүртгэгддэг


Өмнө нь банк, банк бус санхүүгийн байгууллагууд, хуульч, нотариат, нягтлан бодогчид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл өгөх үүрэг хүлээж байв.

Харин шинэ төслөөр энэ төрлийн хэрэгт өртөмтгий салбар болох үнэт металл болон чулуугаар хийсэн эдлэл борлуулагчдыг хамруулахаар тусгаад байна.


Мөн мэдээлэх үүрэгтэй этгээдийн хяналт, шалгалтын тогтолцоог шинэчлэхээр зэхэж байна. Түүнчлэн FATF-ын зарчмын дагуу хяналт шалгалтаа эрсдэлд суурилсан тогтолцоо руу шилжүүлэхээр төлөвлөж байгаа. Тодруулбал, тухайлсан салбар хариуцаж буй төрийн байгууллага, эсвэл мэдээлэх үүрэгтэй этгээд өөрөө харилцагч, үйлчлүүлэгчээ таних үүрэг хүлээх аж.

Олон улсын байгууллагын эдгээр зөвлөмжөөс гадна Монгол Улс дотоодын 20 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний бүх гүйлгээг Монгол-банкнд мэдээлж байгаа юм. [ЗГМ]


Төв банкнаас зарласан төгрөгтэй харьцах ам.долларын ханш (Төгрөгөөр)



Валютын албан нөөц (сая ам.доллараар)



Хадгаламжийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)



ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Гүйлгээний тасралтгүй, найдвартай байдлыг хангана

Нийт төлбөр тооцоо бэлэн бус хэлбэрт хурдацтай шилжиж байна

Г.Илч
ЗГМ

Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анартай ярилцлаа.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн шинэчлэл хэрхэн орнож байна вэ?

Монголбанк Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Монголбанк үйл ажиллагааг нь хариуцдаг, банк хоорондын бүх гүйлгээг дамжуулдаг төлбөрийн системийн техник болон програм хангамжийг шинэчлэх юм. Ингэснээр иргэдийн гүйлгээ тасралтгүй, найдвартай эцсийн хэрэглэгчдээ хүрэхээс гадна нийт системийн аюулгүй байдал ч сайжирна. Мөн сүүлийн жилүүдэд хүчээ авч буй финтекийн хөгжлийг дэмжиж, энэ чиглэлийн компаниудыг төлбөрийн системд оролцох үүд хаалгыг нээж өгнө.

Монгол Улсад төлбөрийн системийн өнөөгийн байдал ямар байна вэ?

Монгол Улсад төлбөр тооцооны үндсэн гурван суваг бий. Үүнд их дүнтэй гүйлгээ буюу нэг сая төгрөгөөс дээш үнэ бүхий гүйлгээний систем, нэг сая төгрөг хүртэлх буюу бага болон төлбөрийн картын систем багтдаг. Эдгээр систем дэх гүйлгээний тоо жилээс жилд өсөж байгаа. Тухайлбал, их дүнтэй гүйлгээний системээр 2016 онд 157 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 2016 оныхоос 1.7 дахин өссөн байна. Үүнээс төлбөрийн картны худалдан авалтад ашигласан гүйлгээний тоо ATM төхөөрөмж ашигласнаас анх удаа давсан. Энэ нь төлбөрийн картны гүйлгээний системийн өсөж байгаа. Мөн нийт төлбөр тооцоо бэлэн бус хэлбэрт хурдацтай шилжиж эхэлсэн. Шинэ хуулийн давуу тал нь юу вэ?

Монгол Улсад төлбөрийн системийн тухай хууль 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Шинэ хуулийн давуу тал нь юу вэ?

Төлбөрийн систем гэх ойлголтыг анх удаа хуульчилж, эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгосон нь энэ хуулийн гол онцлог. Хууль баталснаар төлбөрийн системийн бүх харилцааг нэгдсэн бодлого дор зангидаж, төлбөр тооцооны үйл



С.Батсайхан / ЗГМ©

ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж буй. Тиймээс хуулийн хүрээнд Монголбанк нь төлбөрийн системийн бодлогыг тодорхойлж, системд оролцох шалгуурыг тогтооно. Ингэснээр төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэчлэх нөхцөл бүрдэж, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг нь хангана.

Түүнчлэн үндэсний төлбөрийн системийн тухай хуульд цахим мөнгө хэмээх шинэ ойлголтыг багтаасан. Цахим мөнгөний шинж тэмдэг, түүнд тавигдах шаардлагыг хуульчилсан. Ингэхдээ нэг цахим мөнгө нь нэг төгрөгтэй тэнцэхээр заасан бөгөөд цахим мөнгөний баталгаа нь заавал аль нэг банкинд төгрөгөөр байрших юм.

Сүүлийн үед олон нийтийн анхаарал татаж буй блокчейн технологид суурилсан биткойн

зэрэг криптовалют нь энэ хуульд заасан цахим мөнгөний шинжийг хангаж чадахгүй байгаа. Тиймээс криптовалютыг цахим мөнгөнд тооцохгүй.

Нэг цахим мөнгө нэг төгрөгтэй тэнцэж, баталгаа нь төгрөгөөр банкинд байршина

Монгол Улсын нутаг дэвсгэрт криптовалютыг төлбөр тооцоонд хэрэглэж болохгүй гэж заасан. Харин төлбөрийн системийн тухай хуульд заасан шинж, шаардлагыг хангасан цахим мөнгөийг аж ахуйн нэгжүүд Монголбанкны холбогдох

зөвшөөрлийн дагуу гаргаж, төлбөр тооцоонд чөлөөтэй хэрэглэх боломжтой.

Криптовалют нь өндөр эрсдэлтэй, нэгдсэн байдлаар хянан, зохицуулах боломжгүй. Иймд криптовалютад хөрөнгө оруулаад мөнгөө алдсан, залилуулсан тохиолдолд буцаан олох ямар ч боломжгүй тул эрсдэлтэй хөрөнгө оруулалт болохыг Монголбанкнаас албан ёсоор мэдэгдэж байгаа.

Монгол Улсад төлбөрийн системийн хууль хэрэгжиж эхэлсэнээр төлбөр тооцоонд оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүд бодитой ямар давуу тал бий болох вэ?

Хууль баталж, мөрдөж эхэлснээр төлбөрийн системийн үйл ажиллагаанд хэн, хэрхэн оролцох, үүнийг хэрхэн зохицуулах зэргийг тодорхой болгосон. Мөн төлбөрийн системд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, тавигдах шаардлага ч ойлгомжтой, нарийвчлалтай болсон. Энэ нь цаашид төлбөрийн систем дэх чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, шинэ шинэлэг төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ бий болох, хөгжих таатай нөхцөл болох юм. Түүнчлэн үйлчилгээний зардлыг хэмнэж, хэрэглэгчдийн төлөх шимтгэлийг бууруулах давуу талтай. Мэдээж шинэ төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ бий болсноор иргэдийн аливаа төлбөр тооцоог түргэн шуурхай, хялбар, найдвартай гүйцэтгэх боломж нь нэмэгдэнэ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТҮҮХИЙ ЭД

0.1

Хувь. West Texas төрлийн газрын тосны ханш 0.1 хувиар өсөж, 61 ам.долларт хүрсэн байна.

» ХУВЬЦАА

3.2

Хувь. Хувьцааны хөрвөх чадвар 2017 оны эцэст 3.2 хувь болж, 2016 оны мөн үеэс 0.1 хувиар буурчээ. Уг үзүүлэлтийг зах зээлд арилжсан нийт хувьцааны гүйлгээний дүнг зах зээлийн үнэлгээнд харьцуулан тооцдог байна.

» УУЛ УУРХАЙ

0.2

Хувь. Алтны ханш 0.2 хувиар өсөж, унц нь 1326.96 ам.долларт тэнцэв.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

12.6

Хувь. Монголын хөрөнгийн бирж болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй 313 компанийн хувьцааны төвлөрөл өнгөрсөн оныхоос 12.6 хувиар нэмэгджээ.

» ХӨРШ

2017 оны турш өсөлттэй байсан БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл 2018 онд буурч магадгүй гэж Bloomberg Intelligence-ийн шинжээчид үзэж байна.

» МЕТАЛЛ

7000

Ам.доллар. Лондоны металлын биржид тонн зэсийн ханш 0.2 хувиар дээшилж, 7000 ам.долларыг давав.

» ДЭЛХИЙД

0.1

Хувь. Bloomberg-ээс тооцдог ам.долларын спот индекс 0.1 хувиар буурав.

» ТӨСӨВ

215

Тэрбум ам.доллар. Энэ оны хоёрдугаар сарын байдлаар АНУ-ын төсвийн алдагдал 215 тэрбум ам.долларт хүрч, зургаан жилийн дээд цэгт хүрлээ.

» БАРИЛГА

1.15

Сая. Шинэ орон сууцны ам метрийн доод үнэ дунджаар 1.15 сая төгрөг байгааг “Барилга Эм Эн” компани мэдээлэв.

ВАЛҮТЫН ХАНШ

АНУ доллар	2,395.47
Евро	2,962.84
Японы иен	22.58
ОХУ-ын рубль	42.04
БНХАУ-ын юань	378.86
БНСУ-ын вон	2.25

Эдийн засаг

Роботуудад ажлаа алдахгүйн тулд гурван мэргэжилтэй байх хэрэгтэй

Шинэ эринд эрэлттэй мэргэжил үйлдвэрлэлд нэвтэрлээ

З.Цэлмэг
@tselmegZGM

Үйлдвэрийн уртаас урт үргэлжлэх уйтгартай дамжлагыг өдөржин ширтэх “ял”-аас гэтэлгэж, илүү бүтээлч хөдөлмөр, сонирхолтой зүйлд цаг заваа зарцуулах боломжийг хиймэл оюун ухаан хүн төрөлхөнд олгосон. Масс үйлдвэрлэл эрхлэхийн тулд олон хүн ажиллуулах шаардлагагүй болж, гагцхүү тэднийг орлох роботуудыг хүн өөрөө удирдана. Ойрын 20 жилд бидний хийж буй ажлын тэн хагасыг робот, ямар нэг программ хангамжаар орлуулна гэх таамаг бий. Одоогоор жолоочгүй автомашин, жижиг ачаа илгээмжүүдийг дроноор тээвэрлэж эхэллээ. Тиймээс хүн роботосой илүү чадвартай, дор хаяж гурван мэргэжилтэй байх шаардлага шинэ эринд тулгарлаа. Ийм мэргэжлүүдийн нэг нь мехатроникч. Механик, цахилгааны суурь мэдлэгтэй программ хангамжийн инженерийг ийн нэрлэдэг. Манай улс мехатроникч бэлдээд гурван жил болж байна. Хувийн хэвшлийнхний захиалгаар, “Оюутолгой”, Германы Festo байгууллагын хөрөнгө оруулалтаар Дарханы Уул уурхай, эрчим хүчний политехникийн коллежид бэлтгэж буй аж. ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа “Мехатроникч бэлтгэх тухай 2010 оноос ярьж эхэлсэн бөгөөд гурван жилийн



Орчин үед бүрэн шат дамжлагатай ямар ч үйлдвэрлэл хий, шингэний хослол бүхий автомат-жуулалтын тусламжтай явагдах болсон бөгөөд үүн дээр ажилладаг гол мэргэжилтэн нь мехатроникч аж.

үсэрч хөгжих боломж их байна. Хамгийн гол нь мэргэжлийн боловсрол сургалтад хувийн хэвшлийг оролцоог хангаж байж амжилттай нэвтэрнэ” хэмээв. Лхагва гарагт “Говь” ХК, “Эрэл”, “Оюутолгой” зэрэг үндэсний 11 компанийн төлөөлөл мехатроникийн мэргэжлийн зөвлөл байгуулсан нь аж үйлдвэрийн 4.0 дэх хувьсгал манай эдийн засагт хэдийнэ нөлөөлж эхэлсний идрэл юм. Сонирхуулахад, “Бэст буйдан” компани ч мужаан, эсгүүрийн дамжлагаа автоматжуулсан бөгөөд энэ оноос нано бүрээс хийх гэж буй аж. Харин “Монгол базальт” компани эрдэст чулууг технологийн аргаар чулуун дулаалган иж бүрэн систем, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон. Ухаант хүн уурын хөдөлгүүр бүтээдэг болсноос хойш 200 орчим жил үргэлжилж буй үйлдвэржилтийн I, II, III дахь хувьсгалын жам ёсны үргэлжлэл нь хиймэл оюун ухаан, дижиталчлал болж буйг Google-ийг үндэслэгч, Цахиурын хөндийн хамгийн амжилттай бизнесменүүдийн нэг Сергей Бриний энэ жилийн дэлхийн Эдийн засгийн форумын индрээс хэлсэн билээ. Хиймэл оюун ухаанаар тулгуураа хийсэн дижитал эринд нарийн мэргэжлийн боловсон хүчин, инженерүүдийн эрэлт нэмэгдэнэ гэдэгт улс орнууд, үйлдвэрлэгчид, шинийг санаачлагчид санал нэгддэг. Тиймээс математик, хими, физикт тулгуурласан мэргэжлээр хүмүүсийг тулхуу сургах, тэр ч байтугай боловсролын системийг өөрчлөх шаардлага гарах нь тодорхой аж. Гэтэл ийм ирээдүйд Монголыг авч явах боловсон хүчинийг бэлтгэх сургуулиудад таван оюутан тутмын нэг нь суралцаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. [ЗГМ]



АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ



дижитал эринд эрэлт хэрэгцээтэй мэргэжилтнээ бэлтгэж эхэлж буй нь энэ. Лхагва гарагт болсон “Мэргэжлийн боловсрол, сургалт ба аж үйлдвэрийн 4.0 дэх хувьсгал хэлэлцүүлэг, уулзалт”-ын үеэр ХБНГУ-ын Монгол Улс дахь ЭСЯ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Кристиан Гласс “Монгол Улс одоохондоо нүүрээ түүхийгээр нь экспортолдог ч цаашдаа боловсруулж, нэмүү өртөг шингээж гаргах, өөр салбаруудыг хөгжүүлэх асуудал маш ихээр тулгамдаж байна. Харин аж үйлдвэрийн 4.0 дэх хувьсгал нь энэ бүхнийг боловсруулах, анхдагч болон хоёрдогч түүхий эдээр илүү нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой. Өнөөдрийн хэлэлцүүлгээр Монголд ч гэсэн орчин үеийн технологи, автоматжуулалт нэвтрүүлсэн жишээ олон байна. Тиймээс үйлдвэрлэлийн автоматжуулалтыг удаан хугацаанд нэвтрүүлээд явж байгаа орнуудтай харьцуулахад

өмнөөс элсэлт авсан” гэв. Орчин үед бүрэн шат дамжлагатай ямар ч үйлдвэрлэл хий, шингэний хослол бүхий автоматжуулалтын тусламжтай явагдах болсон бөгөөд үүн дээр ажилладаг гол мэргэжилтэн нь мехатроникч аж. Хамгийн сүүлд гэхэд Дарханы ган бөмбөлгийн, гурилын үйлдвэрүүд бүрэн автоматжсан байна. “Цаашид компьютерийн удирдлагатай үйлдвэрлэлийн бүхий л шугам дээр энэ мэргэжилтэн хэрэгтэй

учраас эрэлт маш өндөр байна” хэмээн Дарханы Уул уурхай, эрчим хүчний политехникийн коллежийн мехатроникийн ангийн багш Б.Пүрэвдорж ярилаа. Аж үйлдвэрийн 4.0 хувьсгалын эринд мэргэжлүүд устаж бас шинээр гарахын зэрэгцээ гибрид болно гэж үзэж буй. Харин мехатроникч бол гибрид мэргэжил юм. ХБНГУ-ын GIZ-ийн шугамаар хэрэгжиж буй “Ашигт малтмалын салбар дахь түнш-

лэлд суурилсан мэргэжлийн боловсрол сургалт” төслөөр монголчууд хиймэл оюун ухаан,

УУЛ УУРХАЙ

Алтны үндсэн ордууд анхаарлын төвд орлоо

“Алт-2” хөтөлбөр хэрэгжилт дээрээ удааширч байна

Б.Баяртогтох
ЗГМ

Алтны салбарынхан хоёр дахь өдрөө чуулж байна. Жил бүрийн өдийд энэ салбарын оролцогчид тухайн жилд хийх ажлаа төлөвлөж, өөрсдийн өмнө тулгарч байгаа асуудлаа “тоого”-н дотроо хэлэлцдэг. Энэ удаагийн хурлыг Монголын уул уурхайн бирж, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбоо хамтран зохион байгуулж байна. Улсын хэмжээнд сүүлийн долоон жилийн турш алтны үйлдвэрлэл тасралтгүй нэмэгдэж, 2010 онд алтны үйлдвэрлэл зургаан тонн байсан бол 2016 онд 18.4 тонныг

давсан. Харин өнгөрсөн онд 20 тоннд хүрч, алтны үйлдвэрлэл огцом нэмэгдсэн. Монголбанкны гадаад валютын албан нөөцийг жилийн дотор 700 орчим сая ам.доллараар зузаатгасан алтны салбарт өнгөрсөн оноос “Алт-2” хөтөлбөр хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн үр дүнд алтны салбарын экспортын орлого 2020 он гэхэд 2015 онтой харьцуулахад 26.7 хувиар нэмэгдэх аж. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга Б.Мөнхтөр “Алтны олборлолтын хэмжээг тогтвортой нэмэгдүүлсний үр дүнд жилд олборлох алтны хэмжээг одоогийн байгаа түвшнээс хоёр дахин нэмэгдүүлэх боломжтой” хэмээн онцоллоо. Харин Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Э.Энхбат дээрх хөтөлбөрийн хэрэгжилт

хангалтгүй байна гэв. Тэрбээр “Цаасан дээр “Алт-2” хөтөлбөр буусан ч үүнд тусгагдсан алт олборлолтыг дэмжих, өсгөхөд чиглэсэн ажлууд огт хийгдэхгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна” хэмээн нэмж хэллээ. Алтны салбарт зайлшгүй хэрэгжүүлэх бодлого, хийх шаардлагатай ажлуудыг тусгасан ч хэрэгжилт дээрээ удааширч байгааг Э.Энхбат учирлалаа. “Алт-2” хөтөлбөр хоёр үе шаттай бөгөөд эхний үе шат энэ онд үргэлжлэх юм. Нийт олборлосон алтаа Монголбанкнд бүрэн төвлөрүүлж чадахгүй байсан тул Ашигт малтмалын тухай хуульд УИХ дөрвөн жилийн өмнө нэмэлт, өөрчлөлт оруулж байлаа. Ингэснээр төв банкинд алтаа тушаасан тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 10 хувь байсныг 2.5 хувь болгож, одоогийн өсөлтийн

“хөрс” бүрдсэн. Хэрэв хуульд өөрчлөлт оруулаагүй бол хууль бус алтны худалдаа далд хэлбэрт улам шилжиж, гадагш урсах алтны урсгал нэмэгдэх байв. Тэгвэл хуулийн өөрчлөлт 2014 оноос хойш алтны салбарын худалдааг шилэн болгож байна. Үүнийг алт тушаалтын дүнгээс харж болох юм. Олон улс, орон нутгийн хамтын ажиллагаа, алтны дэвшилтэт технологи, инноваци сэдвээр үргэлжилж буй алтны чуулга уулзалтаар салбарын хууль эрх зүйн орчныг хөндсөн юм. Алтны роялтиг 2.5 хувь болгосон хуулийн хугацаа ирэх онд дуусгавар болж буй. Үүнийг сунгаж, алтны роялти 2.5 хувь хэвээр үлдвэл алт тушаалт нэмэгдэж, аж ахуйн нэгжүүд ч үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдэнэ гэдгийг тэд хэлж байна. Өнгөрсөн онд 20 тонн алтны 66 хувийг иргэд, үлдсэн хэсгийг нь аж ахуйн нэгжүүд

тушаасан байдаг. Гэтэл компаниуд Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн босгоос болж иргэнээр тушаах тохиолдол бүртгэмэл. Энэ байдлыг өөрчлөх үүднээс уг хуулийн босгыг нэмэх саналтай буйгаа алтны компаниуд илэрхийлж байна. Аж ахуйн нэгжийн албан татварын хуулиар гурван тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд 25 хувийн татвар төлдөг. Гурван тэрбум төгрөгийн борлуулалт нь алт олборлогч компаниудын хувьд харьцангуй бага түвшний орлого гэдгийг Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Э.Энхбат дурдсан юм. Хэрэв хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь алтны гарал үүслийг тодорхойлоход чухал үүрэгтэй аж. Өнөөдрийн байдлаар алтны 608 ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаагаас 169 нь эдийн засгийн

эргэлтэд оржээ. Алтны шороон ордын нөөц багасаж байгаа тул үндсэн ордыг ашиглах шаардлага энэ салбарт тулгарч байна. Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, зөвлөх инженер Л.Лхагвасүрэн “Үндсэн ордуудаа ашигласнаар алтны салбар цэгцэрнэ” хэмээн тэмдэглэсэн юм. Алтны салбарт хүлээлт үүсгэж буй ээлжит төсөл бол алт цэвэршүүлэх үйлдвэр. Энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор алтыг олон улсын зах зээлд шууд борлуулах боломжтой болох юм. Монголбанкны Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа “Алтны тушаалтыг энэ онд 22 тонн хүргэх зорилт тавин ажиллаж байна. Энэ он гарсаар хоёр тонн орчим алт худалдан авсан. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах судалгааны Ажлын хэсэг байгуулагдсан. Тодорхой ажлууд төлөвлөгөөний дагуу урагшилж байна” гэв. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

